

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1059

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох “Үндэсний эвсэл”-ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

**Дүгнэлт**

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор “Үндэсний эвсэл”-ийн ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Үндэсний эвсэл”-ийн мөрийн хөтөлбөр /.....<sup>26</sup>.....хуудас/ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭЛЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan\_Bichigt\2024\0420 GNAG-10.Docx

0001030715



"Үндэсний эвсэл"-ийн Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг Монголын Ногоон Намын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит бус 14 дүгээр Их Хурлын 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар, Монгол үндэсний ардчилсан намын 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн ээлжит 6 дугаар Их Хурлын 9 дүгээр тогтоолын хавсралтаар тус тус батлав.

**“ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-ийн**

**“ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ ДЭМЖЬЕ,  
ҮНДЭСТНЭЭРЭЭ БАЯЖЪЯ”**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**УЛААНБААТАР ХОТ  
2024 ОН**

**00000001**

**ЭРДЭМ НОМ, ЭДИЙН ЗАСГААРАА БАЯН ЧИНЭЭЛЭГ,  
ХҮЧИРХЭГ БАЙХЫГ ЭРХЭМЛЭГЧ ЭЛЭГ НЭГТ МОНГОЛЧУУД АА!**

Үндэсний Эвсэл “ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН” хэмээх Үндэсний ардчилсан үзэл санааг суурь зарчим болгон “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ ДЭМЖЬЕ, ҮНДЭСТНЭЭРЭЭ БАЯЖЪЯ” мөрийн хөтөлбөрөө боловсрууллаа.

Монгол хүчирхэг байсны үндэс суурь нь “ЭВСЭХ ХҮЧ”-тэй байсанд оршино. Гэтэл өнөөдөр улстөрийн намуудын болон нам доторх эрх мэдэл, албан тушаалын төлөөх туйлширсан талцал, тэмцэл болон төрийн эрх мэдэлтнүүд авлига хулгайд хэтэрхий идэгдэж живснээр, ард түмнийхээ итгэлийг алдаж, төр нийгмийн тогтворгүй байдлыг бий болгож, улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжлийг доройтуулж, ҮНДЭСТНЭЭ оюуны болон санхүүгийн ядууралд хүргээд байна.

Үндэсний эвсэл нь иргэдийнхээ хүсэл тэмүүлэл, ҮНДЭСНИЙ АРДЧИЛСАН үзэл баримтлалыг удирдлага болгон, УЛС ТӨРИЙН ТАЛЦАЛ НАМЧИРХАЛЫГ ТАСЛАН ЗОГСООЖ, төрийн эрх мэдлийг нэг улстөрийн намд төвлөрөхөөс сэргийлж, тэнцвэрийг сахиж, эвийг эрхэмлэн ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ ДЭМЖИХ ЗАМААР МОНГОЛ ЭХ ОРНЫХОО ЯЗГУУР ЭРХ АШИГ, ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛЖ үндэстнээрээ амар амгалан БАЯН ЧИНЭЭЛЭГ амьдрахыг эрхэм бодлогоо болгосон.

Жич:

Үндэсний Эвсэл нь мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "АЛСЫН ХАРАА-2050"-тай нийцүүлэн боловсруулсан ба боловсруулах явцад энэ бодлогод алдаа дутагдал байгааг олж харсан бөгөөд цаашид улстөрийн намууд намчирхалаа хаяж, салбар тус бүрийн мэргэжилтэн, эрдэмтэн мэргэдийн хамтаар бодлогод шинэчлэл, тодотголыг зайлшгүй хийх шаардлагтайг цохон тэмдэглэе.

Элэг нэгт Монголчууд аа!

Хүсэл мөрөөдөл, зорилгодоо хүрэхийн тулд эвлэлдэн нэгдэж  
“ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-ийг болон НЭР ДЭВШИГЧИЙГ сонгохыг уриалж байна.

“ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ ДЭМЖЬЕ, ҮНДЭСТНЭЭРЭЭ БАЯЖЪЯ”

*M. [Signature]*

00000002


## “ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-ийг ҮҮСГЭН БАЙГУУЛСНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО:

Монголчууд бид “эвсэх хүч”-тэй байхдаа гарал үүсэл, газар нутаг, шашин шүтлэг, зөрчил тэмцлээс ангид их гүрэн байгуулж, нэг хууль цаазын дор, амар амгалан нэгэн айл болгон төвшитгөх агуу их манлайллыг бүтээж байсан арвин түүхтэй.

Харамсалтай нь өнөөдрийн Монгол манлайлах байтугай өрөөлд дээрэлхүүлж, хойш урагш хяламхийн хардаг, гаднаа хямралтай, дотроо айдастай болжээ. Монголчууд бидний санаа, хараа хоёр өнгөрснийг тойрон эргэж, “Бид цагтаа ялагдашгүй хүчирхэг байсан. Гэтэл өнөөдөр...” хэмээн санаа алдахаас цаашгүй болжээ. Монгол Улс өдрөөс өдөрт уруудан доройтож, Монголчууд маань гутрал, бухимдалдаа гандаж, ирээдүйдээ итгэл алдран цөхрөх боллоо. Үүний учир шалтгаан нь ердөө ШУНАЛ л юм. Үе үеийн улс төрчид бие биенээ үл тэвчиж, эрх мэдэл, албан тушаал, отго жинсний төлөөх талцал тэмцэл, атгаг санаа, зусарч бялдууч, атаа жөтөө, авлига хээл хахууль гээд улс төр шуналд идэгдэж улмаар улс төр нь утга зорилго, эрх ашгийн эрэмбэ, удирдах чадамжаа алдаж гажуудсанд оршино.

Монголчууд ардчиллын замд орж, олон намын систем сонгосон хэдий ч бүх намууд хуучин коммунист намын тогтолцоог хуулбарлан авч, өмнөх нийгмийн ужгирсан үлдэгдэл, өнөө цагийн шуналтан нь улс төрч болж, төрд шургалсан бул хар чулуу болсноор ардчилал эрүүлээр бойжиж чадсангүй. Эдийн засаг маань зах зээлийн замаар тууштай замнасангүй. Төр нь бизнесээс савраа татсангүй. Улс төрийн эрх мэдэл улсаа хөгжүүлэх биш, улс төрчдийн хөлжих хэрэгсэл болж завхрав. Өрсөлдөөн нь өс хонзогнол, мэтгэлцээн нь мөнхийн хэрүүл болов. Хүн ба нийгмийн хөгжил түгжрэлд оров.

Бид элэг нэгт Монголчуудынхаа адил улс төр нь эн тэргүүнд эх орныхоо язгуур эрх ашгийг эрэмбэлдэг, эвийг сахидаг, иргэдээ хамгаалдаг, өмнөх ажил, асуудалдаа өөриймсөг, эрч хүчтэй, чадварлаг, шинжлэх ухаанчаар ханддаг, нийгэм нь айдасгүй, амар амгалангаар дүүрэн хүчирхэг Монголоо сэргээн цогцлоохыг хүсэж байна. Иймийн тулд бид хүсэл зориг нэгт Монголчуудаа төлөөлж, ЦӨХӨРЧ ЯДАРСНЫГ ӨМӨӨРӨН ХАМГААЛЖ, ДУУГАРЧ ЧАДАХГҮЙН ӨМНӨӨС ДУУГАРЧ, ТЭМЦЭЖ ЧАДАХГҮЙН ӨМНӨӨС ТЭМЦЭЖ, улс төрийн намуудын чадаагүй чадна хэмээн итгэл төгсрөн, зориг шулуудан Үндэсний ардчилсан үзлийн дор улс төрийн намуудын нэгдэл бүхий “ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-г нийгмийн захиалгаар үүсгэн байгуулсан.



## “ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-ийн ӨМНӨХ СОРИЛТУУД:

### Нэг: Ардчилал

Монгол Улс ардчиллын замаар замнаад 30 гаруй жилийг ардаа үзжээ. Ардчилал бол иргэдийн гарт засаглах эрх байх, эрх мэдэл нэг талд төвлөрөхөөс хамгаалж, хууль тэгш үйлчилж, нийгэмд шударга ёс тогтож, хүний эрх хангагдаж, хөгжлийн суурь тавигддаг зүй тогтолтой. Энэ зүй ёсны тогтлоороо бол Монголд ардчилал байхгүй.

Монголчууд бидэнд өмнөх коммунист тогтолцооны хүмүүжил болох “хүлцэнгүй” байх нь өнөөдөр ч үргэлжилж байна. Үр дүнд нь ардчилал амь ороогүй ба эрх мэдэл иргэдэд биш улс төрийн намын удирдах бүлэглэлд төвлөрсөн. Монголд хуулийн тэгш үйлчлэл байхгүй ба хууль хүний царай хардаг болсноор нийгэм давхаргат тогтолцоонд орсон. Төр төмөр нүүрээ үзүүлдэг “Ул”-ны тодотголтой доод нэгэн давхаргатай, төрийн нэрээр дургидаг “Улс төр”-ийн гэгдэх дээд нэгэн давхаргатай. Үүнийг дагаад төр хүртэл хүний царай харж, эрх мэдэлтэй даргад бол хайр, эрхгүй иргэдэд бол зайл гэх хүнд сурталтай. Ардчиллын амин сүнс болох тэгш журамт, шударга ёс гэх үнэтэй үгийг улс төрчид утгыг нь алдагдтал хэрэглэсэн. Иргэдийн хувьд ч эдгээр үгсийн бодит хэрэгжилтийг хүлээсээр горьдлого тасарч, үгийн утга нь ч хямдарсан.

### Хоёр: Эдийн засаг

Монголын эдийн засаг нэг талаасаа Коммунист ч юм шиг, нөгөө талаасаа Капиталист ч юм шиг, нэг үгээр хэлбэл эдийн засаг ба нийгмийг холбосон эргэлт бүхий хөгжлийн цогц бодлого байхгүй байна. Улс төрийн нам ба төрийн мэдэлд төсөв зарцуулах эрх, төрийн өмчит үйлдвэрийн газрууд, төрийн албаны

00000003

томилгооны "далд эрх" байдаг учраас төсвөөс хулгайлах, төрийн өмчийг бүлэглэн ашиглах, төрийн албыг зарах гээд улс төр нь өөрөө нэгэн төрлийн ашигтай бизнес болтлоо хөгжсөн. Улсын төсөв нь "Улс төрчдийг тэтгэх сан" гэж хэлэхэд хол зөрөхгүй. Улс төрийн намын гишүүдийн тоо нэмэгдэхийн хэрээр төрийн алба дарга нараар данхайж, бүрдсэн төсвийн дийлэнх нь тэднийг тэжээхэд зарцуулагддаг.

Улс төрчид төсвөө саагаад, төрийн өмчийг самраад, төрийн албыг зараад ч ханадаггүй. Тэд өөрсдийн зохиосон элдэв хууль, журмаар халхалсан дарамт бүхий тусгай зөвшөөрөл, гарын үсэг гэх мэт үйлдэл, эс үйлдлээр хувийн хэвшлийг улс төрд "танил тал тохой татах", улс төрчдийн нөмөр нөөлгөнд ивээгдэх, тэднийг авлигадах нөхцөлийг бүрдүүлдэг. Харин улстөрчид эдгээр муу бүхний шалтгааныг өөрсдөөсөө холдуулж, хувийн хэвшлийг "мөлжигч, шуналтан, дайсан" болгон олны өмнө цоллодог. Үүнд итгэх нь ч олон байдаг. Зөв зүй тогтлоороо бол улс төрчид, хувийн хэвшлийнхэн эдийн засгаа хүчирхэгжүүлэхийн төлөө эмээлийн хоёр бүүрэг лугаа хамтрагчид байх ёстой. Гэтэл үгүй. Улс орноо хөгжүүлэх эдийн засгийн бодлогын хувьд ч улс төрчид мэдлэгийн түвшингээрээ хувийн хэвшлээсээ хол хоцрогдсон. Харамсалтай нь, улс төрчид үүнийгээ мэддэггүй, мэддэггүйгээ ч мэддэггүй, хувийн хэвшлийн үгийг ойшоож сонсдог ч үгүй.

Мөн залуучууд л залуу, олигтой сурахгүй, хөдөлмөрлөхгүй байгаа учраас улс орны эдийн засаг хөгжихгүй байгаа мэт ярьдаг болсон. Бодит байдал дээрээ залуучууд эрсдэлтэй, аюулт нийгмийн эрсдэгч, чанаргүй боловсролын системийн хохирогч болж, хөдөлмөр нь үнэлэгддэггүй хөлсний боол байхыг хүсэхгүй байгаа учраас л гадагшаа дүрвэж байна.

Үр дагаварт нь хувийн хэвшлийн хөдөлмөрөөр бүрддэг төсөв, улс төрчдийн гараар дамжихдаа аж үйлдвэрлэлийг дэмжих дэд бүтэц, нийгмийн салбарын хөрөнгө оруулалт гэхчлэн эдийн засгаа эргээд тэлэх тогтолцоо алдагддаг. Улс төрчдийн хулгайгаас үүдэлтэй эдийн засаг, нийгэм рүү чиглэсэн хөрөнгө оруулалтын дутагдал улсаа барьцаалсан гадаадын зээлээр нөхөгддөг. Тэр зээл нь зориулалтын дагуу зарцуулагддаггүй, хулгайн замаар эрдгийг бид бүгд мэднэ. Өртэй хүн өлмий дор гэгчээр барьцаалагдсан Монгол "Хэний өлмий дор, хэзээ орох вэ" гэдэг асуулт хариултаа нэхэх нь цаг хугацааны л асуудал. Мөн Монголд Улс төрийн нам тойрсон хэмжиж үл барах далд эдийн засаг бий болсон. Үр дагаварт нь хувийн хэвшлийн тэлэлт удааширч, төгрөгийн ханш суларч, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх нь хувийн хэвшлийнхэн, цалин, тэтгэврийн орлоготой иргэдэд хүнд цохилт болдог.

#### Гурав: Нийгэм

Улс төр, эдийн засаг дахь хулгайгаас болж иргэдийн боловсрол, эрүүл мэнд, эдийн засгийн чадавх болон амьдралын чанар доройтсон. Хүнийг төрийн бодлогын төвд байлгана гэсэн лоозон нь байгаа болохоос, бодлого нь манай төрд байхгүй. Өнөөдөр чадварлаг багш болон төгсөгч бэлтгэх боловсролын тогтолцоо зах зээлийн зарчмаас хол хоцорч, нийгэм бүхэлдээ хохирогчид болсон. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдаж, дипломтой залуучууд ажилгүйчүүдийн дийлэнх хувийг эзэлж байхад, хувийн хэвшил ур чадвар бүхий чадварлаг боловсон хүчний асар их дутагдалд орлоо.

Ажил хийгээд ч ашиггүй болсон. Сарын зардал нь цалингаасаа хол давсан. Монгол хүн цалин, орлого, ээмэг, бөгж, хөөрөг, гар утсаа барьцаалж зээл авдаг. Эцэст нь энэ бүгдийг төлөх гэж хилийн чанадад хар ажил хийдэг. Монголд зээлгүй, санхүүгийн дарамтад ороогүй хүн улс төрчдөөс өөр байхгүй. Халамж нэг талдаа хөдөлмөр эрхлэлтийн бодлогын эсрэг хэрэгждэг, нөгөө талдаа улс төрчид эрх мэдэлдээ тогтож үлдэхийн тулд иргэдийг хахуульддаг систем болсон. Үр дагаварт нь нийгэмд ядуурал бий болж, төр нь бизнесийн салбар болтлоо хөгжсөн.

Эрүүл мэндийн салбар мөн л зах зээлийн хөгжлийн зарчмаас хол хоцорсон. Эмнэлгээр үйлчлүүлнэ гэдэг асар их чирэгдэлтэй. Эрүүл мэндийн салбар хүний төлөөх эмч нарын сэтгэл, гадаад, дотоодын хандив тусламж болон хувийн хэдэн эмнэлэг дээр л тогтож байна. Эрүүл мэндийн чадавх, үйлчилгээ, нөхцөл байдалд иргэд итгэх аргагүй болж, мөнгөтэй нь гадагшаа явж, мөнгөгүй нь өвдөөд үлддэг. Цалингаас суутгагдах шимтгэлүүд ирээдүйд үр шимээ өгөх нь баталгаагүй, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сан үйлчлэлийн хувьд ч нэр төдий зүйл болж хувирсан.

Ер нь нийгмийн даатгалын сангаас эхлээд төрийн бүх сан нохойн замаар орсон. Ийнхүү улс төрчдийн хувьд ардчиллын зүй тогтол, эдийн засаг, нийгмийн асуудлууд хөсөр хаягдсан учраас иргэд, хувийн хэвшил хөдөлмөр, санхүүгийн мөлжлөгийн тогтолцоонд орсон. Хүн бүр л хүсэл, мөрөөдөл тээнэ.

Харин түүнийгээ гадаад улс орноос л атаархан харна. “Бид бусад шиг яагаад хөгжиж болдоггүй юм бол?” гэх зарчмын асуултыг өөр хоорондоо ярилцдаг, хамтдаа гасалдаг.

### **“ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ” –ийн ДОТООД ИТГЭЛ:**

Хөгжлөөрөө түүчээлэгч дэлхийн улс орнуудын амжилтын үндэс нь ердөө ардчилал буюу арддаа хамтран засаглах эрхийг олгож, нийгэмдээ тэгш журамт дэглэмийг тогтоож, шилдгээ улс төрд илгээж, тэдгээрээс холч оновчтой бодлого гарч, бодлогынхоо хүрээнд хүүхэд залуучууддаа шилдэг боловсролыг, хувийн хэвшилдээ эрх чөлөөг олгосонд л байгаа юм.


Монгол хүний оюуны чадамж бусадтай харьцуулахад илүү юу гэхээс дутуугүй. Өнөөдөр цөөн хэдий ч монгол хүний чадамж гайхагдсан хэвээр. Тухайлбал, Монгол залуус хиймэл оюун ухаан зохион бүтээх, хүний биед хорт хавдар үүсэхээс өмнөх шинж тэмдгийг тогтоох туяа судлах зэрэг эрдэм шинжилгээний ажлыг нэр хүнд бүхий гадаадын их сургууль, шинжлэх ухааны байгууллагуудад хийж байна. Монголын залуус сансарт өөрсдийн зохион бүтээсэн хиймэл дагуулаа хөөргөж байна. Хувийн хэвшлийнхэн дэлхийн бизнесийн томчуудтай эн зэрэгцэн ширээний ард суух мэдлэг чадамжтай ч болж байна.

Монголчууд бидэнд хүчирхэг Монголоо эргэн цогцлоох боломж дүүрэн байна гэдэгт Үндэсний Эвсэл итгэдэг. Монголчууд бид эвсэж, хүчээ нэгтгэн асах, унтрахын зааг дээр байгаа цучил дээр хэт цахиур цохиж, хөгжлийн галыг бадрааж чадна гэдэгт Үндэсний Эвсэл итгэдэг.

### **“ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ” –ийн МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ОРШИЛ УХАГДАХУУН:**

*“... Улс эрдэм мөхөс болбоос ажил үйлдвэр нь бүдүүлэг, эд хөрөнгө ба сүр хүчин буураад хэрэв эрдэм дэлгэрсэн болбоос элдэв зүйлийн боловсон арга хэрэглэж, эд хөрөнгө зузаан, сүр хүчин их болно. Иймийн тул эдийн засгийг үүрд бат нот арвин зузаан болгоё хэмээвээс ард түмнийг эрх биш ердийн үсэг бичиг утга уянга ба тусгай ашиг тус бүхий эрдэмүүдэд сургахад урьтал болговол зохино.”*

Монголын төр нийгмийн зүтгэлтэн Солийн Данзан, 1923



**ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ ДЭМЖЬЕ, ҮНДЭСТНЭЭРЭЭ БАЯЖЬЯ” мөрийн хөтөлбөрөө ЭРДЭМ НОМ, ЭДИЙН ЗАСГААРАА БАЯН ЧИНЭЭЛЭГ, ХҮЧИРХЭГ БАЙХЫГ ЭРХЭМЛЭГЧ ЭЛЭГ НЭГТ МОНГОЛЧУУДДАА ӨРГӨН БАРЬЖ БАЙНА.**

00000005

# ШИНЭ ЦАГИЙН, ЧАДВАРЛАГ, ӨӨРТӨӨ ИТГЭЛТЭЙ МОНГОЛЧУУД

## ИРЭЭДҮЙН ҮНДЭС – НЯЛХ, БАЛЧИР ҮРС

- Хүүхэд төрөхөөс өмнө болон төрсний дараах эрүүл мэндийн хяналтыг **ЦАХИМ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ** үйлчилгээгээр дамжуулан бүрэн хамруулж, шаардлагатай эмчилгээ, үйлчилгээний хүртээмжийг шуурхай бөгөөд оновчтой байх боломжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлнэ.
- Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, **ЦАЛИНТАЙ ЭЭЖ** арга хэмжээг шинэчлэн зохион байгуулж, цэцэрлэг, сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд өргөжүүлнэ.
- Эхийн төрсний дараах асаргаа, сувилгаанд **ЦАХИМ ЭМЭЭ** үйлчилгээгээр дамжуулан мэдээлэл, зөвлөгөө өгч, эмчилгээ, үйлчилгээг хүртээмжтэй шуурхай, оновчтой байх боломжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгоно.
- Жирэмсний болон амаржсаны дараах үед **ШИНЭ ААВ** санаачилгаар дамжуулан аавуудад ажлын цагийн зохицуулалт хийж, гэрээсээ ажиллах боломжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлнэ.
- Аав болох гэж байгаа болон шинээр аав болсон залуучуудад зориулж гэр бүлд эцэг хүний гүйцэтгэх үүрэг хариуцлагыг дээшлүүлэх санхүүгийн болон хүүхдээ өсгөх асуудлаар хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах **ЦАХИМ ӨВӨӨ** үйлчилгээг нэвтрүүлнэ.

## ӨСӨЖ УРГАХ – БАГА, ӨСВӨР НАСНЫХАН

- Хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд сургуулийн байр, спортын болон урлагийн заал, цайны газар, ариун цэврийн зэрэг тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй суралцагчдад зориулсан, олон улсын стандартад нийцсэн төхируулгат орчинтой **ЕРӨӨ** стандартыг нэвтрүүлнэ.
- Хүүхдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх, сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хичээлээс гадуурх сургалт, сонгон, секц дугуйланг **e-STEM HUB, e-СПОРТ, e-УРЛАГ** үйлчилгээгээр дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.
- Цэцэрлэг, сургуулийн хоолны эрүүл, аюулгүй байдлын стандартыг чанд мөрдүүлж, сургуулийн орчинд **БАГА ҮДИЙН СҮҮ** хөтөлбөрийг эхлүүлж, **ҮДИЙН ХООЛ** хөтөлбөрийг шим тэжээлтэй, амин дэмээр баялаг жимс, ногооны бүтээгдэхүүнээр сайжруулах замаар хүүхдийн эрдэс, тэжээлийн дутагдлыг нөхөхийн зэрэгцээ хүүхдийн шүдний эрүүл мэндийг эрс сайжруулна.
- Хүүхдүүдэд цэцэрлэгийн наснаас нь эхлэн Монголын түүх, соёл, ёс заншил, өв уламжлалыг таниулан, эх оронч үзлийг төлөвшүүлж, бага боловсролын сургалтын төлөвлөгөөт хөтөлбөрийг сургуульдаа үзэх системд шилжүүлэн, нэгээс дөрөвдүгээр ангийнханд **ГЭРИЙН ДААЛГАВАР ӨГДӨГГҮЙ** тогтолцоонд шилжүүлж, **БАГА АНГИЙН БАГШ** санаачлага хэрэгжүүлнэ.
- Ахлах **10–12 ДУГААР АНГИЙНХАН**-д мэргэжил сонгох тогтолцоо, тухайн мэргэжлийн онцлог, нийгэм эдийн засгийн ач холбодол зэргийг таниулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

## БАЯЖИХ СУУРЬ – ЭРДЭМТ Z ҮЕИЙНХЭН

- **"Z"** үеийнхнийг санхүүгийн боловсролтой болгохын тулд сургалтын хөтөлбөрт санхүүгийн мэдлэг, хөрөнгө оруулалтын боловсролыг тусгаж, хөрөнгө оруулалтын **САНХҮҮГИЙН АВДАР** цахим систем, үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэвтрүүлнэ
- Шинжлэх ухаан, технологи, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийлүүлж, **"Z"** үеийнхний ур чадварыг дээшлүүлэх, дадлага хийх боломж олгох, бодит туршлага олж авах, ирээдүйн карьерт нь бэлтгэх **ДӨРӨӨ** системийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.



- Эх дэлхийгээ хайрлах, байгальд ээлтэй аж төрөх дадал зуршлыг төлөвшүүлэх, ногоон бизнес эрхлэх, ногоон орчинд ажиллаж, амьдрах **НОГООН ГАРЦ** санаачилгыг бий болгоно.
- Цахим аюулгүй байдал, цахим сүлжээн дэх ёс зүй, шүүмжлэлт сэтгэлгээг бий болгох, цахим дээрэлхэлт гаргуулахгүй, аюулгүй байдлын хэм хэмжээг мөрдүүлэх чиглэлээр технологийн компаниудтай хамтран ажиллаж, үндэсний хэмжээний **ЦАХИМ ЦАЙЗ** арга хэмжээг хэрэгжүүлнэ
- Залуусын сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарал хандуулж, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх, **САНАА ЗӨВ БОЛ ЗАЯА ЗӨВ** тогтолцоог төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэвтрүүлж, боловсролын байгууллагад тус экосистемийг бий болгоход дэмжлэг үзүүлж ажиллана.

## УЛАМ АРВИЖИХ – ХҮЧИРХЭГ МЯНГАНЫХАН

- Бизнес эрхлэгч, эрхлэхийг эрмэлзэгч Мянганыханд бизнес эрхлэлтийг дэмжих **"БАЯЖ" ЭКОСИСТЕМ**-ийг бий болгоно. Энэ цогц экосистем нь амжилттай бизнес эрхлэгчдийн заавар зөвлөгөө, хамтын ажиллагаа, инновацийг дэмжих таатай орон зай, төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын түншлэл, салбар хоорондын уялдаа холбоотойгоор бизнесийг бойжуулна.
- Үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлт, цалингийн өсөлтийн зогсонги байдлаас шалтгаалж бий болсон ажлын байр, орон сууцны эрэлт, хэрэгцээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн **ТҮРЭЭСЭЭС ӨМЧЛӨХ** санаачилгын хүрээнд бодит үнэтэй **АЖЛЫН БАЙР, ОРОН СУУЦ**-ны нийлүүлэлтээр дэмжиж, илүү хүртээмжтэй болгоно.
- **АЖИЛ, АМЬДРАЛЫН ТЭНЦВЭР**, зохист харьцааг бий болгох зорилтын хүрээнд боломжтой салбарт зайнаас ажиллах сонголт, уян хатан ажлын цагийн системийг **ДЭМЖИХ** нөхцөлийг бий болгоно.
- Мянганыхан амьдрах орчноо уур амьсгалын өөрчлөлтөд зохицуулан бэлтгэх, цаашдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах **НОГООН ИРЭЭДҮЙ** санаачилгыг эхлүүлж, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан тээврийн хэрэгсэл ашиглах, хог хаягдлаа ангилах, дахин боловсруулах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **ТЭРБУМ МОД** хөдөлгөөнийг дэмжин **МОД ТАРИХ "ИЖИЙ ТӨГӨЛ"** ажлыг орон даяар төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын түншлэлийн хүрээнд дэмжиж зохион байгуулна.
- Дижитал эрин үед орон зайнаас үл хамааран өөрийн дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх, санал өгөх, хариуцлагатай **ЦАХИМ ИРГЭН** санаачилгыг хэрэгжүүлж, Мянганыханд тэргүүлэх боломж олгоно.

## АМЖИЛТ ТОГТВОРЖИХ – ДЭВШИЛТЭТ "ИДЭР" НАСНЫХАН

- **"ИДЭР" НАСНЫХНЫ** эрүүл мэндэд онцгойлон анхаарал хандуулах шаардлага зүй ёсоор тулгарч байгааг хүлээн зөвшөөрч, **ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ**-ын талаар мэдлэг, мэдээллийг сайжруулах, **УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ** арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн **ИЖ БҮРЭН ҮЗЛЭГ**, спорт, бялдаржуулах хөтөлбөрт хамруулах, хоол тэжээл, сэтгэл зүйн менежмент, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах **ЭРҮҮЛ "ИДЭР" НАСНЫХАН** арга хэмжээг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын түншлэлийн хүрээнд авч хэрэгжүүлнэ.
- Бизнесийн санаагаа бодит ажил болгох, **ГЭР БҮЛИЙН БИЗНЕС** эрхлэн **УРГИЙН БИЗНЕС**-ийн суурийг тавих, **ШИНЭ МЭРГЭЖИЛ** эзэмшихэд зориулсан дижитал **БИЗНЕС-ИННОВАЦИ** тогтолцоог төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын түншлэлийн хүрээнд бий болгоно. Энэ арга хэмжээг их, дээд сургуулиуд, банк санхүүгийн болон даатгалын байгууллагын үйл ажиллагаатай уялдуулж **ИНКУБАТОР ТӨВ, ТЕХНОЛОГИЙН ПАРК**-уудаар дамжуулан хөгжүүлнэ.
- **"ИДЭР" НАСТНУУДЫН** тэтгэврийн нас ойртож байгаатай холбогдуулан тэтгэвэр, тэтгэмж, хөрөнгө оруулалтын стратегийг удирдах арга, мэдлэг мэдээллээр хангах, тэтгэвэрт гарахад бэлтгэх төлөвлөлтийн зөвлөгөө өгөх үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд **ЭРСДЭЛГҮЙ ТЭТГЭВЭР** дижитал тогтолцоогоор дамжуулан бий болгоно.

00000007



- Сургалтын төлбөрийн өсөлтөөс үүдэлтэй санхүүгийн дарамтыг ирээдүйд хөнгөвчлөх зорилгоор татварын зохицуулалттай **ХАДГАЛАМЖИЙН ХУРИМТЛАЛ** бий болгох боломжтой **"ИРЭЭДҮЙ"** нэрийн данс үүсгэх, эцэг эх, хүүхдүүдэд санхүүгийн мэдлэг олгох санаачилгыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- **ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫГ ХАМГААЛАХ** санаачилгатай уялдуулан **"ИДЭР" НАСТНУУДЫГ** мод тарих, ховор ургамал болон усны эх үүсвэрийг хамгааллын зэрэг байгаль хамгаалах төслүүдэд сайн дураар ажиллах боломжийг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлийн хүрээнд **САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ** цахим тогтолцоогоор дамжуулан бүрдүүлнэ.

#### АМАРЧ ЖАРГАХ – ШИНЭ ЗУУНЫ АХМАДУУД

- Ахмадуудад **ЭРҮҮЛ МЭНД**-ийн цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх, **БАЙРШЛААС ҮЛ ХАМААРАН** хүртээмжтэй болгох, урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийн болон эмийн тусламж, үйлчилгээний **ШУУРХАЙ** тогтолцоог төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлнэ.
- **АХМАДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**-ийг дэмжиж, хагас болон бүтэн цагаар уян хатан нөхцөлөөр ажиллах боломжийг бүрдүүлэх, ахмад настнуудын ур чадвар, дадлага туршлагыг хүлээн зөвшөөрч, зөвлөгөө өгөх, зөвлөн туслах оролцоог нэмэгдүүлэх зорилготой **АЖЛЫН БАЙРНЫ ТАЛБАР, ҮЙЛЧИЛГЭЭГ** төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгоно.
- Нийт тэтгэвэр авагчдад **СУУРЬ ТЭТГЭВЭР** олгох санаачилгыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгоно. **АХМАДЫН САНХҮҮГИЙН БАТАЛГАА**-г хангах, хуримтлалаараа хөрөнгө оруулалт хийх боломжтой, өв залгамжлуулдаг, тэтгэврийн хэмжээ нь **ЖИЛ БҮР** нэмэгддэг тэтгэврийн гурван давхаргат тогтолцоонд шилжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Ахмадуудад өөрсдийн тэтгэврийн хуримтлалыг удирдах, хөрөнгө оруулалт хийж, өгөөж хүртдэг байх, санхүүгийн зөвлөгөө өгөх, санхүүгийн луйвар, мөлжлөгөөс хамгаалах **НЯГТАЛ** тогтолцоог үүсгэнэ.
- Ахмадууд тэтгэвэрт гараад амар тайван аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, боломжийн үнэтэй, талбай багатай, худалдаа үйлчилгээ нь ойрхон **АХМАДЫН ОРОН СУУЦ**-ны хүртээмжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгоно.
- Ахмадуудын нийгмийн оролцоо, хувь хүний хөгжлийг дэмжих **АЗ ЖАРГАЛТАЙ АХМАДУУД** цогц санаачилгыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд ахмадууд олон нийтийн ба сайн дурын үйл ажиллагаанд оролцох, шинэ танил найз нөхөдтэй болох, ахмадын ур чадвар, сонирхлын олон төрлийн клуб, курс, хобби бүлгийн сүлжээ, олон нийтийн төв болон цахим **САЙН УУ** тогтолцоог төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлнэ.

#### ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН – ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН, СПОРТ БА АМРАЛТ

- Монгол хүн эрүүл орчинд ажиллаж, амьдрах үндсэн нөхцөл болох хот суурин газрын агаар, ус, хөрсний зэрэг **ОРЧНЫ БОХИРДОЛ**-ыг технологийн шинэчлэл, төр, хувийн хэвшил, олон нийтийн оролцоотойгоор **БУУРУУЛНА**.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН** үндэсний хөдөлгөөний хүрээнд эрүүл зан үйл, идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах зорилго бүхий **НЭГ ЭРҮҮЛ МЭНД** цогц цахим тогтолцоог бий болгох замаар **ЗӨВ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ**-аа сонгоход дэмжлэг үзүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.
- Эрүүл нийгмийг төлөвшүүлэхэд **СОНИРХОГЧДЫН, ҮНДЭСНИЙ** болон **МЭРГЭЖЛИЙН СПОРТ**-ын ач холбогдлыг онцлон, спортын авьяас чадварыг хөгжүүлж, иргэдийг спортоор хичээллэх боломжоор хангах, тив дэлхийн тавцанд өрсөлдөх баг тамирчдад дэмжлэг үзүүлэх **МОНГОЛ ОЛИМП** тогтолцоог үүсгэж, спортыг дэмжих орчин бүрдүүлнэ.
- Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах хүрээнд **ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН, СПОРТЫН БАЙГУУЛАМЖУУД**-ыг шинэчилж, олон нийтийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх төслүүдийг дэмжих ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.
- **АРХИ, ТАМХИНЫ ЗОХИСГҮЙ ХЭРЭГЛЭЭ**, мансууруулах бодисын хор уршгаас үүдэн гарах нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр **"ЭРҮҮЛ БИЕД САРУУЛ УХААН"** зорилтот



тогтолцоог бий болгож, тусламж шаардлагатай зорилтот бүлгүүдэд зөвлөгөө өгөх, эмчлэн анагаах, эрүүл мэндийн тогтолцоонд уялдуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна

## САРУУЛ УХААНД ЭРҮҮЛ БИЕ – БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНД

### БОЛОВСРОЛ

- Монголын **УЛАМЖЛАЛТ СУРГАЛТЫГ** орчин үеийн хөтөлбөртэй хослуулан, хувилбарт сургалтын хэлбэрээр хөгжүүлж, **СУРАЛЦАХУЙН ЗАНГИЛАА** бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын **ШИНЭ ЗУРАГЛАЛ, ТОГТОЛЦООГ** төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлнэ.
- Монгол соёл уламжлалд суурилсан олон сонголт, хувилбар бүхий биет болон зайны хосолсон сургалтаар тогтолцоогоор дамжуулан **МОНГОЛ ХҮҮХЭД, ИРЭЭДҮЙН ИРГЭН**-ийг төлөвшүүлнэ. **СУРАЛЦАГЧИЙН АВЬЯАС, ЧАДВАР, СОНИРХОЛД** суурилсан уян хатан, нээлттэй, өөрийн үнэлгээ болон удирдлагатай суралцахуйг дэмжинэ.
- Мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг **АМЬДРАЛ АХУЙ, АЖИЛ МЭРГЭЖИЛТЭЙ НЬ ХОЛБОХ** буюу мэргэжлийн сургуулиудыг **ҮЙЛДВЭРЛЭЛ МЕНЕЖМЕНТИЙН БАГ** болон **МЭРГЭЖЛИЙН ХОЛБООД**-той нягт уялдахуйц **ШИНЭ ТОГТОЛЦОО**-нд шилжүүлнэ.
- **ИХ, ДЭЭД СУРГУУЛИУД**-д бэлтгэгдэж зүй ирээдүйн мэргэжилтнийг ажлын байрны эрэлт нийлүүлэлт, Монгол Улсын хөгжлийн **ҮНДСЭН БОДЛОГО “АЛСЫН ХАРАА 2050”**-той уялдуулж, хөтөлбөрийн шинэчлэлийг уян хатан байх тогтолцоонд шилжүүлэн, **БОЛОВСРОЛ** болон **АЖЛЫН БАЙР НЬ ХАРИЛЦАН УЯЛДААТАЙ БАЙХ** бодлогоор хөгжүүлнэ.
- Ахисан түвшний сургалт, **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ**, технологийг **ШИНЖЛЭХ УХААНЫ ПАРК**-ийн тогтолцоо болон бизнесийн чиг баримжаатай хөгжүүлж дэмжинэ.

### ЭРҮҮЛ МЭНД

- Бүсийн төвүүдэд орчин үеийн **ОНОШИЛГОО**-ны төвүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, **ИРГЭДИЙН ЦАГ, ЗАРДЛЫГ ХЭМНЭНЭ**.
- **АГААРЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТОГТОЛЦООГ** төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгож, яаралтай тусламжийн түвшинг олон улсын зэрэглэлд хүргэнэ.
- Аймгуудад **ХАВДРЫН ЭМЧИЛГЭЭ, СУВИЛГААНЫ ТӨВ**-үүдийг нэгдсэн эмнэлгүүдийн дэргэд олон нийт, олон улсын байгууллага, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, үйл ажиллагааны зарим санхүүжилтийг **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ**-тай холбох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- **СУМДЫН** Ерөнхий боловсролын сургуулийг **СУРГУУЛИЙН ЭМЧ, СЭТГЭЛ ЗҮЙЧТЭЙ** болгож, хүүхэд, залуусын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг **ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН** санаачилгын хүрээнд зохион байгуулна.
- **УЛАМЖЛАЛТ АНАГААХ** ухааны эмнэлгийг хувийн хэвшилд түшиглэн байгуулахыг бодлогоор **ДЭМЖИЖ**, эрдэм шинжилгээ, судалгаа болон уламжлалт **ЭМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛНЭ**.

## ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ БА ХУВИЙН ХЭВШИЛ – ҮЙЛДВЭРЖИЛТИЙН ШИНЭ ЭРИН

*Handwritten signature*

00000009

## АЖ ҮЙЛДВЭРИЙН ИННОВАЦИ – УУЛ УУРХАЙ БА ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ

- **АЖ ҮЙЛДВЭР ХӨГЖҮҮЛЭХ**–дээ ISO, EN зэрэг **ОЛОН УЛСЫН СТАНДАРТ**–д нийцсэн төслийг дэмжинэ. Хөрөнгө оруулалтын илүү таатай эрх зүйн орчны бүрдүүлэх хүрээнд гаалийн татвар төлөх хугацаа, хэмжээ, зураг төсөл, ТЭЗҮ–д ноогдох НӨАТ, Монгол Улсын мэргэжлийн байгууллагад хүлээн зөвшөөрөгдөх шинэчлэл хийн, импортыг орлох чиглэл барьж урт, дунд ба богино хугацаагаар эрэмблэнэ. Хил орчмын бүсийг аж үйлдвэрийн эргэлтэнд оруулах, газар олголт, зарим салбарын бүтээгдэхүүн хуваах гэрээ, АМНАТ–ыг эргэн харж, түр горимд байршуулсан бараа, ажиллах хүчний эрх, зөвшөөрөл зэргийг төсөл хэрэгжих нийт хугацаанд хүчинтэй байдлаар олгодог болгоно.
- Аж үйлдвэрийн салбарын **ӨРСӨЛДӨХ ЧАДВАР, ТОГТВОРТОЙ БАЙДАЛ**–ыг нэмэгдүүлэх, инновацийг дэмжих, орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилгоор импортын тоног төхөөрөмж, техникийн НӨАТ, гаалийн татварын таатай эрх зүйн орчныг үе шаттайгаар бүрдүүлнэ.
- Аж үйлдвэрийн өсөлтийг экологийн тогтвортой байдал, **НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ МЕНЕЖМЕНТ**–тэй уялдуулах хүрээнд салбарын дэд бүтэц, аж үйлдвэрийн паркуудын хэрэгцээг хангахуйц **УСАН ХАНГАМЖ**–ийн системийг хөгжүүлнэ. Цахилгаан станцуудад бүрэн шаталттай, ашигт үйлийн **ИТГЭЛЦҮҮР ӨНДӨРТӨЙ ТЕХНОЛОГИ** нэвтрүүлж нефтийн хайгуул, олборлолт, боловсруулалтыг эрчимжүүлэн, чанартай нефть бүтээгдэхүүнээр хангах замаар **УЛС ОРНОО ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАРААТ БАЙДЛААС ГАРГАНА СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ**–ний үйлдвэрлэлийг дэмжих, ашиглах таатай нөхцөлийг бүрдүүлэх, цаашид хүрээлэн буй орчны **БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ**, арилгах арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авч хэрэгжүүлнэ.
- Аж үйлдвэрийн салбарын хувьсан өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээнд нийцсэн, чадварлаг, туршлагатай инженер, техникийн **МЭРГЭЖИЛТЭН**, боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, **ГАДААД, ДОТООДОД СУРГАХ**, төгсөгчдийг эх орондоо ажиллах нөхцлийг төр, хувийн хэвшилтэй хамран бүрдүүлнэ. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн материаллаг баазыг сайжруулах, ажлын байрд **ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГА** хийх, туршлагатай инженер, техникийн ажилтан, суралцагсдад тодорхой цагаар сургалт хийх тэнцвэрт нөхцөлийг бүрдүүлнэ.
- Стратегийн хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтой **ТОМООХОН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн төслүүдэд баталгаа гаргах, олон улсын санхүүжилтийн хөтөлбөрүүд, Европын Холбооны “Global Gate Way”, гадаад улс орны **ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ** (ECA) зэрэгт хамруулан бага хүүтэй, таатай нөхцөлөөр тоног төхөөрөмж худалдан авах боломж, нөхцөлийг бий болгон дэмжиж ажиллана.

## ХӨНГӨН, ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ БА КЛАСТЕР ХӨГЖИЛ

- **ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН**–ий хүрээнд хүнсний боловсруулах үйлдвэрүүдийг шинэчлэх, нөөц, түүхий эдийн хангамж, байршилд тулгуурлан шинээр байгуулах, нэмүү өртөг шингээх, хүнсний лабораториудыг чадавхижуулах **ИЖ БҮРЭН СТРАТЕГИ**–ийг бий болгоно. Эрүүл ахуйн стандарт хангасан агуулах, зоорийн цогцолбор, зориулалтын ложистик төвүүдийг байгуулах ажлыг эрчимжүүлж, олон улсын стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх, цаашид **ХҮНС ЭКСПОРТЛОГЧ** болох ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- Судалгаа хөгжүүлэлт, инноваци болон байгаль орчинд ээлтэй шинэ технологи ашиглан, үнэгүйдээд байгаа **АРЬС, ШИРИЙГ** шинэлэг тогтолцоо бүхий бэлтгэн нийлүүлэлттэй **КЛАСТЕР** үйлдвэрлэлээр боловсруулах ажлыг дэмжиж, **МАЛЧНЫ ХОТОНД МАЛЫН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ ЦЭН**–ийг сэргээн бий болгох ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- **ТҮҮХИЙ НООС БОЛОН НОЛУУР**–ын **ДАХИН БОЛОВСРУУЛАЛТ**–ын түвшинг үе шаттайгаар **90 болон 60 ХУВЬ**–д тус, тус хүргэж, **НОЛУУРАН УТАС ЭЭРЭХ** үндэсний үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар олон улсын ноолуурын зах зээлд Монгол Улсын байр суурийг бэхжүүлнэ. Монгол Улсын



Ерөнхийлөгчийн **ЦАГААН АЛТ** санаачилгыг дэмжиж, ноос ноолууран бүтээгдэхүүний экспортын өсөлтийг дэмжих **ЦОГЦ ТОГТОЛЦОО**–г төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгоно.

- Хөнгөн үйлдвэрлэлийн бусад салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, **ИМПОРТЫГ ОРЛОХ** болон **ЭКСПОРТОД ЧИГЛЭСЭН**, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүнд, тэр дундаа **МЭДЛЭГ ШИНГЭСЭН** үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний **ХУДАЛДААНЫ** нэгдсэн **ТОГТОЛЦООГ** үүсгэж, **ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ**–тэй холбож, сөрөг үр дагавраас зайлсхийх **ЭКСПОРТЫН ДААТГАЛ**–ын системийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгоно.

#### УРГАДАГ АЛТ – УХААЛАГ ХӨДӨӨ АЖ АХУЙ

- Хөдөө аж ахуйн салбарт төр, хувийн хэвшил, олон улсын болон эрдэм шинжилгээний байгууллагуудын түншлэлээр **РОБОТЖУУЛАЛТ, АВТОМАТЖУУЛАЛТ, ХИЙМЭЛ ОЮУН УХААН** нэвтрүүлж нэгж бүтээгдэхүүний өртгийг бууруулан, чанар стандартыг сайжруулж, хөдөлмөрийг хөнгөвчилнө. Хөдөө аж ахуйд **ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАХ** болон ХАА–н үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалах **ДААТГАЛ**–ын цогц системүүдийг хэвшүүлнэ.
- **ГАЗАР ТАРИАЛАН**–гийн салбарт **МЕХАНИКЖУУЛАЛТ**–ыг нэмэгдүүлж, эрдэс болон биологийн гаралтай **БОРДОО**–ны үйлдвэрлэлийн суурь кластерыг бий болгоно. Тариалангийн талбайг **МАЛААС ХАМГААЛАХ, ХАЦААЖУУЛАХ**, ойн зурвас байгуулах, ээлжлэн тариалах системийг урамшууллын бодлоготой уялдуулан, таримлын төрлийг олшруулах замаар **ХӨРСНИЙ ҮРЖИЛ ШИМ**–ийг хамгаална. Дотоодын үйлдвэрлэлээр гурил, төмс, гол нэрийн хүнсний ногоо, ургамлын тосоор бүрэн хангаж, илүүдлийг экспортлоно. Усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэлд ус болон эрчим хүчний **ХЭМНЭЛТ**–тэй технологи нэвтрүүлнэ. Босоо тариалангийн систем, экспортын **ХҮЛЭМЖ, ҮРИЙН ЧАНАР** хангамж, **УРГАМАЛ ХАМГААЛЛЫН** чиглэлээр **ШИНЭЧЛЭЛҮҮД**–ийг эхлүүлнэ.
- **БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙ**–г **МАНЛАЙ МАЛЧДААР** түүчээлүүлэн, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, **ЭРСДЭЛ ДААХ ЧАДАВХИ**–тэй тогтолцоог малчид, үйлдвэрлэгчид, орон нутгийн оролцоо, санаачилгад тулгуурласан “хамтын шийдвэр гаргалт”–аар бүрдүүлнэ. **БЭЛЧЭЭРИЙГ ЗҮЙ ЗОХИСТОЙ АШИГЛАХ**, нөхөн сэргээх, **МАЛЫН ҮҮЛДЭР УГСААГ** сайжруулах болон **МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД**–ийг хамгаалах, сургалт, үйлдвэрлэлийн **МАЛ ЭМНЭЛГИЙН** төвүүдийг бүсүүдэд төр, хувийн хэвшил, ХААИС болон эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцоотой бий болгоно. Технологи, инновацийг бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.
- **ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙ**–д өндөр **ҮР АШИГТАЙ МАЛ**–ын тоог нэмэгдүүлж, төв суурин газрын хүн амыг **СҮҮ, ШИНЭ МАХ, ӨНДӨГ** болон хэрэгцээт бусад бүтээгдэхүүнээр хангах зорилгоор үйлдвэрлэлийн бүсүүдийг **ТЭЖЭЭЛ** үйлдвэрлэлийн байршил, чадавхи, ханган нийлүүлэлтийн тогтолцоотой уялдуулан хөгжүүлнэ.
- Хөдөө аж ахуйн **МЭРГЭЖИЛТЭН** бэлтгэх тогтолцоонд **ШИНЭЧЛЭЛ** хийж, төгсөгчид орчин үеийн шинэ техник, технологи бүхий ажлын байрны шаардлага хангахуйц мэргэжлийн ур чадвар бүрэн эзэмшсэн байх жишиг тогтооно. Төр хувийн хэвшил, ХААИС, олон улсын байгууллагуудын түншлэлийн хүрээнд **ХАА–Н ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ПАРК** байгуулах замаар инноваци бүтээх, баялаг бүтээгч (энтерпрейнэр) бэлтгэхэд анхаарч, ЭША, төгсөгчдөд гарааны бизнес эрхлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

#### БАХАРХАЛТ УЛАМЖЛАЛ – НОГООН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- Үндэсний язгуур урлаг, өв соёлд суурилсан **МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, СОЁЛ, ӨВ УЛАМЖЛАЛ, ҮНЭТ ЗҮЙЛС**–ээ хадгалан тээх “**ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД**” түүнийг дагасан аялал жуулчлалыг хөгжүүлнэ.



00000011

- Монголын уламжлалт баяр наадам, түүх соёлын өвд тулгуурласан эко аялал жуулчлалыг **БҮРГЭДИЙН БАЯР, САРЛАГИЙН БАЯР, ТЭМЭЭНИЙ БАЯР, МОНГОЛ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АМТАЛГААНЫ САР, ЦАГААН ИДЭЭНИЙ САР** зэрэг арга хэмжээнүүдтэй хамтатган зохион байгуулж, улирлын онцлогтойгоор төрөлжүүлэн хөгжүүлнэ.
- Бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн мал маллах, мал хэрэгцээлэх арга ажиллагаа, цагаан идээ боловсруулт түүхэн уламжлалт хоолны соёлд суурилсан эко аялал жуулчлалыг дэмжиж, **ЖИНХЭНЭ НҮҮДЭЛЧИД** тогтолцоог үүсгэн хөгжүүлнэ.
- Монгол орны **БАЙГАЛИЙН УНАГАН ТӨРХ**, археологи, палеонтологийн дурсгалт өв, нүүдлийн соёл, түүхэнд тулгуурласан, төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлж, **НҮҮДЭЛЧНИЙ СОЁЛ**-ын аялал жуулчлалын тогтолцоог улиралын, агаарын тээврийн **ХӨХ ТЭНГЭР** санаачлага болон бусад тээврийн бодлоготой уялдуулна.
- Бүс нутгийн онцлогт тулгуурлан өвөрмөц шийдэл бүхий бүтээн байгуулалтыг нутгийн иргэдийн оролцоотойгоор байгуулж, **УГСААТНЫ ЗҮЙ, ҮНДЭСТЭН ЯСТНЫ МОНГОЛ ХУВЦАС**-ны төрөлжсөн загварын үзэсгэлэн, уралдаан зохион байгуулж, тэдгээрийг дагасан аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

### ӨВ СОЁЛЫН ДАРХЛАА – БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ

- Монголын соёлын **БАЯЛАГ ӨВ**-ийн элементийг орчин үеийн үйлдвэрлэлийн үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэвтрүүлнэ. Энэхүү систем нь Монголын бараа бүтээгдэхүүнийг **ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД ТАНИУЛАХ**, соёлын өвөрмөц өгүүлэмж, уламжлалт гар урлалаар дамжуулан **ҮНЭ ЦЭН**-ийг өсгөнө.
- Урлаг, гар урлал, хөгжим, уран зохиол зэрэг соёлын өвд түшиглэсэн салбаруудад **ИННОВАЦИЙГ ДЭМЖИЖ**, шинэ технологи, зах зээлд нэвтрэх боломжийг бий болгох замаар **СОЁЛЫН ӨВӨРМӨЦ ОНЦЛОГ**-ийг хадгалж, сурталчлан таниулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.
- Орчин үеийн загвар (дизайн) үйлдвэрлэлийн техниктэй хослуулан уламжлалт урлаг, гар урлалд чиглэсэн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт явуулах замаар **МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ХОЙЧ ҮЕД**-ээ өвлүүлнэ.
- Мэдлэг, ур чадвар, соёлын бүтээгдэхүүн солилцох олон улсын түншлэлийг дэмжиж Монголын соёлын бүтээгдэхүүний шинэ зах зээлийг нээж, аялал жуулчлал болон хөрөнгө оруулалтыг татах замаар **МОНГОЛЫН СОЁЛЫН ӨВИЙГ ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНД ҮНЭЛЖ**, тогтвортой байлгахад хувь нэмэр оруулна.
- Соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд **ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ**-д хүчтэй дэмжлэг үзүүлэх механизм бий болгож, соёлын бүтээгдэхүүнийг танилцуулах, таниулах **МОНГОЛД ҮЙЛДВЭРЛЭВ** цахим худалдаа, сурталчилгааны тогтолцоог бий болгоно.

### ИРЭЭДҮЙН ХУРДАСГУУР – ДЭД БҮТЭЦ

- Дэвшилтэт ложистикийн систем, ухаалаг технологи нэвтрүүлэх замаар хил дамнасан худалдааг оновчтой болгохын тулд **БООМТЫН ШИНЭЧЛЭЛ**-ийг үргэлжлүүлж, олон улсын чанартай авто зам, төмөр замын дэд бүтэц байгуулах ажлыг **ЧӨЛӨӨТ БҮС**-үүдэд цогц байдлаар хөгжүүлж, **ДАЛАЙД ГАРАХ ГАРЦУУДЫГ НЭМЭГДҮҮЛЭХ** арга замыг эрэлхийлнэ. **АЛТАНБУЛАГ** чөлөөт бүсийг: **ЦАХИЛГААН ТЕХНИК**, түүний сэлбэг, засвар үйлчилгээний, мөн **ЗАМЫН-ҮҮД** чөлөөт бүсийг: уул уурхайн бус **ТҮҮХИЙ ЭД, МАТЕРИАЛ**-ын худалдааны чиглэлээр тус, тус төрөлжүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж, боомт орчмын хөгжлийг дэмжинэ.
- **ЭРЧИМ ХҮЧ, ДУЛААН**-ы хангамж, нийлүүлэлтийн найдвартай, тогтвортой байдлыг хангах зорилгоор одоо ажиллаж байгаа цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугамыг шинэчлэх, **УХААЛАГ СҮЛЖЭЭ**-ний технологид төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулна. **САЛХИ, НАР, БИО ЭРЧИМ ХҮЧ, УСАН ЦАХИЛГААН СТАНЦ** зэрэг сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн газар олголтод уян хатан байх нөхцөлийг бий болгож, орон нутгийн иргэдтэй хамтран

*Handwritten signature*

ажиллаж, цаашид **ХУВИЙН** хэвшлийн хөрөнгө оруулалт, олон улсын түншлэл, хөшүүргээр дэмжиж, сэргээгдэх эрчим хүчийг төв шугамд нийлүүлдэг механизмыг боловсронгуй болгоно.

- Суурин болон хөдөө орон нутагт **АВТОМАТ ЖОЛООДЛОГОТой ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, ТЕХНИК** болон **НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ТӨХӨӨРӨМЖ** ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ, **5G** болон дараагийн үеийн харилцаа холбооны дэвшилтэт технологийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлнэ.
- Үндэсний агаарын орон зайд **НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ТӨХӨӨРӨМЖ**-ийн нислэгийг аюулгүй үйлдэх боломжийг хангахын тулд агаарын хөдөлгөөний удирдлагын дэвшилтэт системийг **АГААРЫН ОРОН ЗАЙ**-н дэд бүтцийг шинэчилж, тусгайлсан агаарын орон зайн коридор, буух/хөөрөх бүсүүдийг өргөжүүлнэ. **АВТОМАТ ЖОЛООДЛОГОТой ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ**-д зориулсан замын тусгай эгнээ, зохицуулалт хийнэ. Түүнтэй холбоотой аюулгүй байдал, нууцлал, тодорхой зохицуулалт, бодлогын тогтолцоог төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, олон нийтийн аюулгүй байдал, итгэлцлийн хүрээнд боловсруулна.

#### ИРЭЭДҮЙД АНХДАГЧ – ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИ

- Биотехнологи, инженерчлэл, байгаль орчны чиглэлийн судалгааны тоног төхөөрөмж, лабораториудыг чанаржуулж, одоогийн лабораториудаас **НЭЭЛТТЭЙ ЛАБОРАТОРИ** бий болгон, бизнес эрхлэгчид, салбарын мэргэжилтнүүд, гарааны бизнес эхлүүлэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, олон улсад нээлттэй салбар дундын **ЭХЛЭЛ** цахим тогтолцоог бий болгоно.
- Бизнес эрхлэгчдийн экосистем, инновацийг нэн тэргүүнд дэмжих, **ОЮУНЫ ӨМЧ**-ийн эрхийг хамгаалах, судалгааг арилжааны болгох үйл явцыг хялбарчлах, **СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ**, гарааны бизнест хөрөнгө оруулалт бий болгох, инкубатор, хурдасгуур **ШИНЖЛЭХ УХААНЫ ПАРК**-ийг боловсронгуй болгоно.
- Монгол Улсад шилжүүлэн нутагшуулах технологиудад технологийн түвшний үнэлгээ хийнэ. Судалгаа, инновацийг дэмжих зорилгоор **ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**-тай өндөр технологийн салбар дахь гарааны бизнест чиглэсэн **ГАРААНЫ САНХҮҮЖИЛТИЙН САН**-г бий болгохыг дэмжинэ.
- Олон улсын тэргүүлэх их, дээд сургуулиуд, судалгааны байгууллагууд, технологийн компаниудтай **СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛ**-ийг бий болгох, оюутан, судлаач солилцооны хөтөлбөр, хамтарсан судалгааны төсөл, технологи дамжуулах чиглэлээр идэвхтэй ажиллаж, **ОЛОН УЛСЫН ИННОВАЦИЙН СҮЛЖЭЭ**-нд Монголын судлаачид, бизнес эрхлэгчдийг нэгдэхийг дэмжиж, мэдлэгийн солилцоог хөнгөвчлөх, **ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРАХ** боломжийг бүрдүүлнэ.
- Нүүрс, химийн үйлдвэрлэл, **УСТӨРӨГЧ**, газрын ховор элемент, **ЗЭС** болон бусад металл баяжуулах, цэвэршүүлэх технологи, сэргээгдэх эрчим хүч, цөлжилт, **БЭЛЧЭЭР**, тогтвортой мал аж ахуй, **ЭМИЙН УРГАМАЛ** зэрэг Монгол Улсын өвөрмөц давуу тал, сорилттой уялдсан судалгааны чиглэлүүдийг нэн тэргүүнд дэмжинэ.

#### АЛСЫН ЭХЛЭЛ – ХИЙМЭЛ ОЮУН УХААН, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, РОБОТ, САНСРЫН БОЛОН АЭРОНАВТИКИЙН ХӨГЖИЛ

- Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, дэвшилтэт технологи бий болгох үндэс суурь **ХИЙМЭЛ ОЮУН УХААН** ба мэдээллийн технологийн хөгжлийн хүчирхэг экосистем **МОНГОЛ ОЮУН** төвийг байгуулж, чадварлаг боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, инноваци болон арилжааны үйл ажиллагааг дэмжих төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгоно.
- Хөдөө аж ахуй, эрүүл мэнд, ложистик, төв суурин газрын менежментийн зэрэг салбарт робот техник, автоматжуулалтыг нэвтрүүлэхэд шаардлагатай экосистем болох **РОБОТТЕХНИК, АВТОМАТЖУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**-ийг байгуулж, инноваци хөгжүүлэхэд чиглэсэн цогц төлөвлөгөө, мэдлэг солилцох, ур чадвараа хөгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль болон олон улсын технологийн байгууллагатай хамтран, орчин үеийн лаборатори, туршилтын



00000013

байгууламжид хөрөнгө оруулалт хийх, роботын шийдлийг хөгжүүлэхэд гарааны бизнес, ЖДҮ-ийг дэмжих инкубаторыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийнэ.

- Сансар судлалын тэргүүлэгч агентлагуудтай **ТҮНШЛЭЛ** байгуулж, олон улсын консорциумд элсэх, сансрын шинжлэх ухаан, технологийн олон улсын **ОГТОРГУЙ** бага хурлыг тогтмол зохион байгуулах замаар олон улсын сансрын хамтын нийгэмлэгт Монгол Улсын байр суурийг бэхжүүлнэ. **САНСРЫН ХАМТАРСАН ХАЙГУУЛ**, судалгааны төслүүдэд оролцох, технологи дамжуулах, мэдлэг солилцох, сансрын шинжлэх ухаан, технологийн чадавхийг бэхжүүлнэ.
- Сансрын судалгааны ажиглалтын газар, **ХИЙМЭЛ ДАГУУЛ ХӨГЖҮҮЛЭХ** байгууламж, **САНСРЫН ХӨЛӨГ ХӨӨРГӨХ** дэд бүтцийн бүтээн байгуулалтыг онцлон сансрын судалгааны санаачилгыг санхүүжүүлэх, дэмжих үндэсний стратеги боловсруулна. Байгаль орчны хяналт, харилцаа холбоо, үндэсний аюулгүй байдал зэрэг бодит асуудлыг шийдвэрлэх боломжтой хиймэл дагуулын хэрэглээнд анхаарлаа хандуулж, улс орны эдийн засгийн багцыг төрөлжүүлэхийн тулд **САНСРЫН ТЕХНОЛОГИ**-д хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- **ҮНДЭСНИЙ АГААР МАНДАЛ, САНСАР СУДЛАЛ**-ын мэргэшсэн эрдэм шинжилгээний хүрээлэнг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах замаар Монгол Улсын агаар, сансрын тээврийн чадавхийг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ. Олон улсын стандарт, дүрэм журмын дагуу инженер, оператор, техникийн ажилтнуудыг бэлтгэх хөтөлбөрт анхаарлаа хандуулна.

## САНХҮҮ, ЭРСДЭЛИЙН ДААТГАЛ

- **ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО** нэвтрүүлэхийг дэмжиж, төрийн болон хувийн хэвшлийн хяналтын үүргийг даатгалын салбараар гүйцэтгүүлж, **ЧАНАРГҮЙ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ**-нээс бусдад учруулсан хохирлыг гүйцэтгэгчийн өмнөөс даатгалын компаниуд төлдөг тогтолцоог бий болгоно.
- Эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ үйлчилгээний зардлыг үр ашигтай зарцуулахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, **ХУВИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО**-г нэвтрүүлнэ. Иргэд улсын ЭМД-ын сангаас давсан зардлаа хувийн даатгалаас төлүүлдэг болж, **ГҮЙЦЭТГЭЛИЙН** систем нэвтэрснээр эрүүл хүн, эрүүл мэнддээ анхаардаг иргэн ЭМД-ын сангийн хуримтлал үүсэж, өвчний түүхээ нэгдсэн байдлаар гаргаснаар **ҮР ДҮНГҮЙ ОЛОН ШИНЖИЛГЭЭ ОНОШИЛГОО ХИЙЛГЭХГҮЙ** болно.
- **БАТАЛГААНЫ ДААТГАЛ**-ыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд орохгүй их хэмжээний мөнгө банкинд тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа, чанарын баталгаа байдлаар **ТҮГЖИГДДЭГ** байдлыг хална.
- Эрүүл мэнд, **ЭД ХӨРӨНГИЙН ДААТГАЛЫН ЧАНАР**, өртөг, хүртээмжийг сайжруулах хүрээнд төр, хувийн хэвшлийн хүчирхэг түншлэлийг бий болгох замаар боломжийн үнэтэй, хөдөө орон нутаг, малчид зэрэг хүн амын олон талт хэрэгцээнд нийцсэн **ДААТГАЛЫН ИЖ БҮРЭН БАГЦ**-уудыг бодлогоор дэмжинэ.
- **ДААТГАЛЫН АЧ ХОЛБОГДОЛ**-ын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор эрсдэлийн удирдлага, санхүүгийн боловсролд чиглэсэн үндэсний хөтөлбөрүүдийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж, **ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ** стратеги болон даатгалын үр өгөөжийн талаар олон нийтэд мэдээлж сурталчлан, эрүүл мэнд, эд хөрөнгө, санхүүгийн аюулгүй байдлыг хамгаалахад болон үндэслэлтэй шийдвэр гаргахад туслахыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажил хэрэг болгоно.

## АВЛИГА, ХУЛГАЙГААС АНГИД ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛ

АВИЛГА ХУЛГАЙГҮЙ ЭРҮҮЛ ТӨСӨВ, ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ

*Handwritten signature*

00000014

- Олон улсын ил тод байдлын байгууллагаас гаргадаг **АВЛИГЫН ҮЗҮҮЛЭЛТ 5 (ТАВАН) ИНДЕКСЭЭР УХРАХ** нь Гүйцэтгэх засаглал **ОГЦРОХ ҮНДЭСЛЭЛ** гэж үзнэ. Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих **ЭРҮҮЛ ТӨСӨВ**-тэй байхын тулд төсвийн үр ашигтай зарцуулалтыг өрийн зохистой удирдлагатай хослуулна. Төсвийн зардлыг үндэсний тэргүүлэх зорилтуудтай уялдуулан оновчтой болгож, **ТӨСВИЙН ҮРЭЛГЭН БАЙДЛЫГ ХАЛЖ**, хөрөнгө оруулалтыг өндөр үр нөлөө бүхий төслүүдэд төвлөрүүлнэ.
- **ТӨР ХУВИЙН ХЭВШИЛТЭЙ ӨРСӨЛДӨХГҮЙ** байх. Бизнесийн, төрийн бус байгууллагын хийж чадах болон чадаж байгаа ажлыг төр хийхгүй байх. **ШИЛЖҮҮЛЭХ, АУТСОРСИНГ ХИЙХ** замаар бизнес дэх төрийн оролцоог тэглэнэ.
- Үндэсний аюулгүй байдалд харшлахаас бусад салбарын **ТӨРИЙН ӨМЧИЙГ ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР ХУВЬЧЛАХ** замаар **ТӨСВИЙН ҮР АШИГГҮЙ ЗАРДЛЫГ ТАНАЖ**, хувьчлалаас орох орлогыг **БАЯЛАГИЙН САН**-д төвлөрүүлж, **МЕНЕЖМЕНТ**-ийг нь мэргэжлийн багаар удирдуулан **ХӨРӨНГИЙГ** өсгөж, зорилтот арга хэмжээнд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Өмч хувьчлах үйл ажиллагааг ил тод явуулж, өрсөлдөөнийг нэмэгдүүлэн, эдийн засгийн **ЭРХ МЭДЛИЙН ТӨВЛӨРЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ**-д анхаарч ажиллана.
- **ТАТВАР ТӨРӨӨС ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ГЭЖ ӨГЧ БАЙГАА ТӨЛБӨР, АЛБА ГУВЧУУР БИШ.** Бодит эдийн засгийн загварчлалд суурилсан **ТАТВАРЫН БААЗ СУУРЬ**-ийг өргөжүүлж, дагаж мөрдөх зардлыг бууруулахын зэрэгцээ, татварын хууль, түүнтэй холбогдох **ЖУРМУУДЫГ ХЯЛБАРЧЛАХ**, татвараас зайлсхийхтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлж, татварын ачааллыг **ИЛҮҮ ТЭГШ ХУВААРИЛАХ** тогтолцоог боловсронгуй болгон, **ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ** хийнэ. Татвар **ДЭЭРЭМ биш ДЭМЖЛЭГ** байна.
- Инноваци нэвтрүүлэх, бизнес эрхлэх, ажлын байр бий болгоход чиглэсэн жижиг, дунд бизнес (**ЖДҮ**), **ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД** болон банкны зээлийн босго давахгүй иргэдэд зорилтот зээлийн хүртээмжийг сайжруулах ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үзүүлнэ.

#### СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ШИНЭЧЛЭЛ

- Монгол Улсад үйлдвэрлэж, импортолж байгаа бараа, бүтээгдэхүүний чанарыг олон улсын түвшинд хүргэх, импортлосон бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавихын тулд **ШИЛДЭГ НОГООН СТАНДАРТ**-ыг мөрдөж **МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАР**, үр ашгийг дээшлүүлнэ.
- **МЭДЭЭЛЭЛД СУУРИЛСАН ШИЙДВЭР** гаргах, бодлого боловсруулахад шаардагдах үндсэн суурь статистикийн **МЭДЭЭЛЛИЙГ ҮНЭН ЗӨВ** цуглуулах, боловсруулах, түгээх статистикийн иж бүрэн тогтолцоог шинэчилнэ.
- **СТАТИСТИКИЙН БОДИТ ТООН** мэдээний тогтолцоог бий болгох хүрээнд **ДЭВШИЛТЭТ АНАЛИТИК**, хиймэл оюун ухаан, цахим тогтолцоог ашиглан мэдээлэл цуглуулж, **ДҮН ШИНЖИЛГЭЭ**-г оновчтой болгоно.
- **ИХ ӨГӨГДӨЛ**-ийг статистик болон стандарт бодит интеграци нь урьдчилан таамаглах загвар, илүү нарийн өгөгдлийг боловсруулах боломж, хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд сорилтыг **УРЬДЧИЛАН ХАРЖ, ДАВАН ТУУЛАХ** боломжийг бий болгоно.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн **ISO, EN, NSC** зэрэг **СТАНДАРТ**-ын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар улс даяар мөрдүүлэн ажиллах суурийг тавина.

#### МӨНГӨ САНХҮҮГИЙН БОДЛОГО

- Төсвийн зарлагын тэлэлтийг багасгаснаар **МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ УЯН ХАТАН ХЭРЭГЖҮҮЛЭХ** орон зай бий болгож, банкны салбарын тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авна.
- Нэр хүнд бүхий **ОЛОН УЛСЫН САНХҮҮ**-гийн байгууллага болон түүний салбар нэгжийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлснээр **БАГА ӨРТӨГТЭЙ, УРТ ХУГАЦААНЫ**





**САНХҮҮЖИЛТ**-ийн эх үүсвэрийг хангаж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн мөнгөний зорилтот бодлогоор дамжуулан эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжинэ.

- Монгол Улсыг **АЗИ-НОМХОН ДАЛАЙН** бүс нутгийн **САНХҮҮГИЙН ТӨВҮҮДИЙН НЭГ** болгох хууль, эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- ДНБ-ий өсөлттэй уялдуулан **ТӨСВИЙН** зардалд **САХИЛГА БАТ**-ыг хатуу мөрдөж, тогтвортой өсөлтийн зорилтод нийцсэн мөнгөний ухаалаг бодлого хэрэгжүүлнэ.
- **БАНК, САНХҮҮ, ДААТГАЛ**-ын салбар дахь хөрөнгө оруулалтыг дэмжих, **ӨСӨЛТ, ИННОВАЦ**-ийг бий болгох, өрсөлдөх чадвартай санхүүгийн орчныг бүрдүүлнэ.

## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ БА ДИЖИТАЛ ӨӨРЧЛӨЛТ

- **ТЕХНОЛОГИОР ТЭРГҮҮЛЭГЧ УЛС ОРНУУД** болон олон улсын байгууллагатай стратегийн түншлэлийг бий болгож, дижитал өөрчлөлт, технологийн солилцоонд чиглэсэн **ДЭЛХИЙН ФОРУМ, СҮЛЖЭЭ**-нд тогтмол оролцоно.
- Төрийн үйлчилгээг хялбарчлах, хүртээмжтэй, үр ашигтай, ил тод болгох **eMONGOLIA** системийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Мэдээллийн цогц санг хөгжүүлж **ҮЛЭМЖ ӨГӨГДӨЛ**-ийг үүсгэнэ.
- Бүс нутгийн болон төрийн байгууллагуудыг холбосон **МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ЦАХИМ СИСТЕМ**-ийг бий болгож төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд мэдээлэл солилцох боломж бүрдүүлнэ.
- Шинэ үеийн **МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ** болох **САНСРЫН ХОЛБОО ХАРИЛЦАА, 6G ТЕХНОЛОГИ**-ийн судалгаа хөгжүүлэлтүүдийг эхлүүлнэ.

## ИРГЭДЭЭ СОНСДОГ, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА

- Төрийн алба **МЭРГЭЖЛИЙН, НЭЭЛТТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ, ЦОМХОН** байх өөрчлөлтийг орон нутаг, засаг захиргааны нэгжлийн шинэчлэлтэй уялдуулан хийж, **УЛС ТӨРИЙН НАМЫН КОММУНИСТ ТОГТОЛЦООГ БҮХ ТҮВШИНД УСТГАНА**.
- Төрд **АВЛИГА** үүсгэж болох бүх нөхцлийг төрөөс ангижруулж, **ЦАХИМЖУУЛНА, ХУВИЙН ХЭВШИЛ, ТББ**-аар гэрээн ий үндсэн дээр гүйцэтгүүлнэ.
- Төрийн үйл ажиллагааг **ИЛ ТОД** болгох замаар авлигатай тэмцэж, **ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ САНГ** үүсгэн, иргэд төрийн үйл ажиллагаа, төсвийн хуваарилалт, шийдвэр гаргах үйл явцтай холбоотой мэдээллийг авах боломж бүрдүүлнэ.
- Төрийн албаны үйлчилгээг **ХҮРТЭЭМЖТЭЙ, ШУУРХАЙ**, төрийн үйлчилгээг **ХЯЛБАР** болгоно. Хүлээлтийн хугацааг эрс багасгаж хэрэглэгчдэд зөлтэй болгоно.
- Бодлого боловсруулахад **ИРГЭДИЙН ДУУ ХООЛОЙ**-г тусгах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж **ЦАХИМ ТОГТОЛЦООГ** ашиглан, иргэдийн **ОРОЛЦОО**-г хангаж, төрийн **ШИЙДВЭР** гаргах үйл явцыг хүртээмжтэй болгоно.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД БОЛОН БҮГДИЙГ ТЭГШ ХАМРУУЛАХ

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн үйлчилгээ авахдаа заавал биечлэн очих шаардлагагүй болгож, цахим сүлжээ ашиглан, үйлчилгээ авахад **ХЯЛБАР НЭВТРЭХ** боломжийг бий болгоно.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ**, үйлчилгээг хүртээмжтэй болгоно. Энэ чиглэлээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийг мэргэшсэн сургалтад хамруулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх **ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТЫГ ӨӨРЧЛӨХ**-д чиглэсэн гэгээрлийн ажлуудыг хамтран хийнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж **АЖИЛД** авч буй бизнес эрхлэгчдийг **УРАМШУУЛАХ**, хувиараа хөдөлмөр эрхлэх санаачилгыг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулна.



- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалж байгаа хууль тогтоомж, бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, **ХУВЬ ХҮНИЙ ЭРХ**-ийн зөрчлийн талаар мэдээлэх, цаг тухайд нь хүлээн авах механизмыг бий болгоно.

## ЭРҮҮЛ УЛС ТӨР – ШУДРАГА ЁСНЫ ХҮСЭЛ

### ШУДАРГА ШҮҮХ

- Бүх шатны шүүхийн **ШҮҮГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ** дүрэм, журмыг боловсронгуй болгож, **ХАРААТ БУС** байдлыг хангана.
- Шүүхийн системийн үр дүнтэй ажиллагааг хангахын тулд зарим төрлийн маргааныг **ТҮРГЭВЧИЛСЭН** байдлаар шийдвэрлэдэг шүүхийн тогтолцоог бий болгоно.
- Шүүгчид, шүүхийн ажилтнуудыг сургалт, хөгжлийн хөтөлбөрт хамруулж, **МЭДЛЭГ, УР ЧАДВАР**-ыг дээшлүүлж, дотооддоо болон **ОЛОН УЛСАД** Монгол Улсын шүүхийн системийн **НЭР ХҮНД**-ийг сэргээнэ.
- **ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ ХҮНИЙ ЭРХИЙГ** хамгаалдаг болгоно.
- Шүүхийн системд **МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ**-ийн дэвшлийг ашиглаж, шүүхийн үйл ажиллагааг **ИЛҮҮ ШУУРХАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧИРЭГ ДЭЛ БАГАТАЙ** болгоно.

### ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

- Ажлын байрны цалинд дүн шинжилгээ хийж, **ЭМЭГТЭЙ** болон **ЭРЭГТЭЙ** ажилтны ур чадвар, ажлын үр дүнг үндэслэн **ЦАЛИНГИЙН ЯЛГАА**, цалингийн тэгш бус байдлыг **АРИЛГАНА**.
- Боловсролын салбарт жендэрийн ялгааг арилган, багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлж, эмэгтэй, эрэгтэй хүүхдийн **СУРАЛЦАХ** боломжийг **ИЖИЛ ТҮВШИНД** байлгахад чиглүүлнэ.
- Мэргэжлийн онцлогоос хамаарсан жендэрийн асуудалд анхаарал хандуулж, **АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ХҮЙСИЙН ТЭГШ БАЙДАЛ**-ыг хангаж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Хүүхдээ төрүүлсэн эхчүүдийн **АЖЛЫН БАЙРЫГ ХАДГАЛАХ** бодлогыг сайжруулж, **ХӨХҮҮЛ ЭЭЖИЙН АЖЛЫН ХУВААРЬ** бий болгоно.
- Жендэрийн талаарх **УЛАМЖЛАЛТ ОЙЛГОЛТ**-ыг өөрчлөх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендерт суурилсан **ХҮЧИРХИЙЛЭЛ**-ийн талаар сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, **БУРУУ ХАНДЛАГЫГ ХАЛНА**.

### ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО БА ЭРХ МЭДЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

- Нийгэм, улс төрийн бүхий л салбарт **ЗАЛУУЧУУДАД ГЭРЭЛ АСААНА**. Залуучууд намгүйгээр хөгжин дэвжих, салбарын мэргэжлийн холбоодод идэвхитэй оролцоотойгоор хөгжих бүхий л бололцоог бий болгон **ЗАЛУУЧУУДЫН ДУУ ХООЛОЙ**-г сонсдог **МЕХАНИЗМ** бүрдүүлнэ.
- Залуучуудын ажлын дахь хөдөлмөрийн бүтээмжийн **ҮНЭЛГЭЭГ БОДИТОЙ, ШУДАРГА** болгоно.
- Залуучуудад сайн дурын үйл ажиллагаа, олон нийтийн арга хэмжээнд **ОРОЛЦОХ СОЁЛ**-ыг төлөвшүүлэх, нийгэмд эерэг өөрчлөлт авчрах, иргэний нийгмийн хариуцлагыг ухамсарлах санаачилга өрнүүлнэ.
- Залуучуудын **МЭРГЭЖЛИЙН ХӨГЖИЛ**, ур чадварын өсөлтөд чухал нөлөө үзүүлэх **ИНТЕРНШИП** хөтөлбөрийг бодит ажлын орчинд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгоно.
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд залуучуудыг **ГАДААД ХЭЛ** сурах, бусад улсын залуучуудтай холбоо тогтоох, харилцах цахим тогтолцоог бий болгоно.

*Handwritten signature*

00000017

## НАМЫН ОРОЛЦОО БА ЭРХ МЭДЛИЙГ БАГАСГАХ

- **ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛАЛ** болон шийдвэр гаргалтанд **НАМ БУС**, олон нийтийн болон мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчинг сайжруулна.
- **НАМ** албан ёсны **ГИШҮҮНЧЛЭЛГҮЙ**, олон нийт чөлөөтэй хамрагдах, нээлттэй байх орчныг бүрдүүлнэ.
- Улс төрийн намын **САНХҮҮЖИЛТ**-ийг **ИЛ ТОД** болгоно.
- Засаглалд оролцож байгаа улс төрийн хүчин, намууд **НАМЫН ЭРХ АШИГ**-г суурилсан шийдвэр гаргахаас **ТАТГАЛЗАХ** баталгаа гаргадаг болгоно.
- Төрийн байгууллага дахь улс төрчдийн оролцоог багасгаж, **УЛС ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД** болон **УИХ**-ын гишүүд төрийн албан хаагчидтай **ЗӨВХӨН АЛБАН ХЭРГИЙН ХАРИЛЦАА**-г үүсгэх зохицуулалттай болгоно.

## ТЭТГЭВЭР, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖИЙН БОДЛОГО

- **ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САН**-гийн тогтолцоог төрийн даатгалын системтэй зэрэгцүүлэн бий болгоно.
- Халамжийн бодлогыг цэгцлэн, зорилтот бүлгийг нарийвчлан тодорхойлоход анхаарч **ХАЛАМЖ ХҮРТЭГЧЭЭС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ** болгох бодлогыг хэрэгжүүлнэ.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэтгэврийн сангийн хуримтлалыг **ӨСГӨХ, САЙЖРУУЛАХ** тогтолцооны эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааг орон нутаг, **САЛБАРЫН ОНЦЛОГ**-той уялдуулан хэрэгжүүлж, албан бус сектороос албан секторт ажил эрхлэх сонирхлыг нэмэгдүүлнэ.
- Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлыг **ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ**-ийн хүрээнд шилжүүлж, банк санхүүгийн, баталгаатай системтэй уяна.

## ЧАДДАГТАЙ НЬ ХАМТРАН АЖИЛЛАХ – ХОТ, ХӨДӨӨГИЙН НОГООН ХӨГЖИЛ

### УХААЛАГ ЗАСАГЛАЛТАЙ БУХИМДАЛГҮЙ ХОТ

- Хотыг санхүү, татвар, төсвийн хувьд **БИЕ ДААСАН**, дүрэм журмаа өөрөө баталдаг, иргэдээс шууд сонгогддог зарчимд үндэслэн, дэлхийн хотуудын жишгээр **"МЭР"-ИЙН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЖ**, засаглах болон гүйцэтгэх чадварыг дээшлүүлнэ.
- **ХОТ** Монгол Улсын **ХӨГЖЛИЙН НЭГ ГАРЦ** гэдгийг хүлээн зөвшөөрч, тойргийн эдийн засагтай, ногоон орчинтой, цэцэрлэг, сургууль, дэлгүүр, эмнэлэг, нийтийн ахуйн үйлчилгээ бүгд 20 минутын зайд байх **УХААЛАГ ХОТЫН ЦОГЦ, ШИНЭ ТӨЛӨВЛӨЛТ**-ийг чаддагтай нь хийж, шаардлагатай хууль эрх зүйн зохицуулалтыг хийнэ.
- **ХИЙМЭЛ ОЮУН УХААНД** суурилсан ухаалаг систем бүхий хяналтын системийг **ХОТ БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД** нэвтрүүлж, олон нийтийн оролцоотой төсвийн зарцуулалт, **ХЯНАЛТ**, удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- **eMONGOLIA** төрийн цахим үйлчилгээг хөгжүүлж, иргэд **ГАР УТАСНААС** төрийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэхэд тулгамддаг хууль, эрх зүйн зөрчлүүдийг арилгаж, олон улсын жишигт нийцсэн цахим засаглалыг бэхжүүлнэ.
- Бохирдол бага ялгаруулах, **ХОГ** хаягдалгүй хэрэглээ болон хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах дэвшилтэт, үр дүнтэй, нөлөөлөл бүхий **ИРГЭН, ХУВИЙН**

М. С. Д.

**ХЭВШЛИЙН САНАЛ**, санаачилгыг **"ҮНЭГҮЙ АЛТ"** үндэсний аяны хүрээнд өрсөлдөөний зарчмаар, нээлттэй, ил тодоор урамшуулах захиргааны журам, зохицуулалтаар дэмжинэ.

#### СУДАЛГААНД СУУРИЛСАН АЛСЫН ХАРААТАЙ ХӨГЖИХ УХААЛАГ, ЦОГЦ ХОТ

- Хүн амын нутагшил суурьшлын ерөнхий төлөвлөгөөг тэргүүн ээлжинд боловсруулж батлуулахад идэвхтэй ажиллаж, судалгаанд суурилсан **БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ, ШИНЭ ДАГУУЛ ХОТ**–уудын ерөнхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, төсвийн үргүй зардалд **ХЯНАЛТ ТАВИХ** нөхцөлийг бүрдүүлнэ.
- **УЛААНБААТАР** хотыг хөгжлийн хоёр дахь шат **МЕГА** хотын хэв шинжрүү хандаж байгааг хүлээн зөвшөөрч, аж үйлдвэрийн бүсүүдийг салбар чиглэл бүрд төлөвлөн, хүчирхэг цөм бүхий **ДАГУУЛ ХОТ**–уудаар **КЛАСТЕРЧЛАН** хөгжүүлнэ.
- **УЛААНБААТАР** хот нь хотын 2 төв, дэд 5 төв, олон нийтийн 26 төв, төрөлжсөн 4 төвтэй, эдийн засгийн үр ашигтай байх үндсэн зарчимд тулгуурласан **ЦОГЦ, ЦОМХОН, ГАМШГИЙН ЭРСДЭЛГҮЙ, СОНГОЛТОД НИЙЦСЭН ШААРДЛАГАТАЙ, УХААЛАГ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ** хот байх төлөвлөлт, хөгжүүлэлтийг төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- **"ЯАРМАГ" ХОТЫН ШИНЭ ТӨВ**–ийг үндэсний онцлогийг шингээсэн, орчин үеийн архитектурын шийдэл, даалгавартай **БИЗНЕС ЦЕНТР**, ажлын байр, түүнийг дагасан түрээсийн орон сууцны концепцоор төр, хувийн хэвшлийн хүрээнд хөгжүүлнэ.
- **ХОТЫН ХУУЧИН ТӨВ**ийн ~~ӨНГӨ ТӨРХИЙГ ХЭВЭЭР ХАДГАЛЖ~~, сэргээн засварлах, хүчитгэх ажлуудыг төр, хувийн хэвшлийн хүрээнд тогтмол хийж гүйцэтгэх үйл ажиллагааг дэмжинэ.

#### УХААЛАГ ХӨШҮҮРГЭЭР УРАГШЛАХ УТААГҮЙ ХОТ

- **ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭ ЭХ ҮҮСВЭР**–үүдтэй холбох, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг **СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ** үйлдвэрлэх, худалдах таатай орчныг бүрдүүлж, **ДУЛААНЫ АЛДАГДАЛ БАГАТАЙ НОГООН БАРИЛГЫН** стандарт нэвтрүүлэх замаар **ЯНДАНГ ЦӨӨЛЖ**, дулааны хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлнэ.
- **ГЭР ХОРООЛОЛЫГ** сэргээгдэх ~~эрчим хүчийг дэмжсэн~~ үндэсний онцлогийг харуулсан архитектурын онцлог шийдлээр аялал жуулчлалын онц сонирхолтой бүс болгон, алсын хараатай хөгжүүлэх шаардлагад тулгуурлан өртгийг багасгах ухаалаг хурдасгуур **БАРИЛГА ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ** төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд дэмжин хөгжүүлж, агаар, орчны бохирдлыг арилгана.
- Үндэсний онцлогтой, аялал жуулчлалын шинэ бүс **ГЭР ХОРООЛОЛЫН** дахин төлөвлөлтөд **ГАЗАР, НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ ҮНЭЛЭХ** үнэлгээг "Тэрбум мод" төсөл санаачилгатай уялдуулан, тодорхой үнэлгээний системтэй болгож, ухаалаг санхүүжилтийн механизм, хөшүүргээр хотын **НОГООН БАЙГУУЛАМЖ, ДЭД ТӨВҮҮДИЙН ХӨГЖИЛ, ТЭЛЭЛТИЙГ** төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлийн хүрээнд дэмжин эрчимжүүлнэ.
- Үндэсний онцлогтой **ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ**, инженерийн хийцлэлийн шийдэлд байгаль орчинд ээлтэй, ногоон технологийн дэвшил, хөгжүүлэлтийг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд өргөжүүлэн иргэдийг урт хугацаатай **НОГООН ЗЭЭЛ**–д хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хотын шинэ төв, дэд төвүүдэд ажиллаж, амьдрах ажилчин, албан хаагчдын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд **"ОРОН СУУЦНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ", "НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ ФОНД"**–оос санхүүжих нөхцөл сайтай **ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ**–ны цогц хөтөлбөр, төлөвлөгөөг эрхзүйн зохицуулалтын хамт шинэчлэн боловсруулж батлуулан, ажилтан, албан хаагчид, нийгмийн эмзэг бүлэг, ахмад настнуудын тогтвортой ажиллаж, амьдрах нийгмийн баталгаа, хотын шинэ төв, дэд төвүүдийн тогтвортой хөгжлийг хангах төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр дүнтэй үйл ажиллагааг дэмжин эрчимжүүлнэ.



## БУХИМДАЛГҮЙ, ТҮГЖРЭЛГҮЙ ЗАМЫН ДЭД БҮТЭЦТЭЙ НОГООН ХОТ

- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан, дэд төвүүдийг түшиглэсэн **АВТО ЗАМ**-ын сүлжээг **ТӨЛӨВЛӨЛТӨНД НИЙЦСЭН, ОЛОН ТҮВШНИЙ ОГТЛОЛЦОЛ БҮХИЙ** байх менежменттэйгээр төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлээр гүйцэтгэж, авто замын **ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ**, түгжрэлийг сааруулна.
- Насжилт хэтэрч, эрсдэлд орсон инженерийн шугам сүлжээг шинэчлэх, технологийн шинэчлэлийг хийх ажлын хүрээнд өвлийн улирлын онцлогт тохирсон, олон талт эдийн засаг, нийгмийн үр өгөөж бүхий **ГАЗАР ДООРХ ХОТ**-ын төлөвлөлтийг төр, хувийн хэвшлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- Хүүхдийн тооноос хамаарсан **СУРГУУЛИЙН АВТОБУС**-тай байх шаардлагыг хувийн хэвшлийн сургуулиудын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн суурь шаардлагад, төрийн өмчийн сургуулиудад боломжит нөхцөлөөр, ухаалаг зохицуулалтаар үе шаттай хэрэгжих тодорхой стандарт, эрхзүйн зохицуулалтыг **"ЦАГ ҮЕ-ХҮСЛИЙН ХӨТӨЧ"** аяны хүрээнд боловсруулан батлуулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн оролцоотойгоор оргил цагийн замын ачааллыг бууруулна.
- **ОЛОН ТӨРЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН** үйлчилгээг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд дэмжин, **ЦАХИЛГААН** болон **ХИЙН** түлшээр ажилладаг байхаар хөгжүүлж, **ЯВГАН ЗАМ, ДУГУЙН ЗАМ**-ын хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- **НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ТӨХӨӨРӨМЖ** ашиглан **ХҮРГЭЛТ** хийх орон зайн дэд бүтэц болон хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, **НОГООН ХҮРГЭЛТИЙН СИСТЕМ**-ийг эзлүүлнэ.

## ГАМШГИЙН ЭРСДЭЛГҮЙ ТАЙВАН ХОТ

- **"ГАМШГИЙН ЭРСДЭЛГҮЙ ХОТ"** аяны хүрээнд **БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН** чанар, насжилтыг тодорхойлох, болзошгүй асуул, **ГАЗАР ХӨДЛӨЛТӨД ТЭСВЭРЛЭХ ЧАДВАРТ ХЯНАН БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙЖ**, паспортжуулах, эрсдэлтэй барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, олон улсын туршлага, хамтын ажиллагааны хүрээнд төр, хувийн хэвшлийн чадавхи, оролцоог нэмэгдүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.
- Гамшгийн үед **ТҮР ХОРГОДОХ СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙР**-уудыг бий болгох, **БЭЛЭН БАЙХ** эрх зүйн зохицуулалтуудыг хийж, гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийн цогц төлөвлөгөөг боловсронгуй болгон хөгжүүлэхэд идэвхитэй хамтран ажиллана.
- **"ГАМШГИЙН ЭРСДЭЛГҮЙ ХОТ"** аяны хүрээнд **ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**-ийг дэмжиж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллана.
- Ундны **УСНЫ** нөөцийг нэмэгдүүлэх, усны нөөцийг хуримтлуулах, хаягдал усыг дахин боловсруулах, зохистой ашиглах **ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН ЦОГЦ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД**-ийг төр, хувийн хэвшлийн хүрээнд **ЧАДДАГТАЙ НЬ** хамтран ажиллаж, хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- **БИЕ ДААСАН ДУЛААНЫ ЭХ ҮҮСВЭР**-үүдийн бүтээн байгуулалтыг дэмжиж, цаг үеийн нөхцөл шаардлагад нийцсэн эдийн засгийн өндөр үр өгөөж бүхий дэвшилтэт технологиудыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд судлан хөгжүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тасралтгүй сайжруулна.

## БҮС НУТГИЙН НОГООН ХӨГЖИЛ, ХӨДӨӨГИЙН СЭРГЭН МАНДАЛТ

- Бүс нутгийн эдийн засгийг төрөлжүүлж, **БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**-ын хүрээнд **ГАЗАР ОЛГОЛТ**-ыг **ЛИБЕРАЛЧАЛЖ**, ажлын байр, шинэ бүтээн байгуулалт бий болгосон иргэн, аж ахуйн нэгжийг **УРТ ХУГАЦААНЫ ТАТВАРЫН ЯЛГААТАЙ БОДЛОГО**-оор дэмжинэ. Олон улсын болон дотоодын тээвэр, зорчигч тээвэр, ложистикийн нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- Төрөөс **УСНЫ ТАЛААР БАРИМЛАХ БОДЛОГО**-ыг шинэчилж, мастер төлөвлөгөө гарган, ус хуримтлуулах, усны эх үүсвэрээр эрчим хүч үйлдвэрлэх, усан цахилгаан станцыг барих зөвшөөрөл



олгож, **ОРЛОГЫГ ТУХАЙН АЙМАГ, БҮС НУТАГТ** төвлөрүүлэн зарцуулах эрх зүйн орчныг бий болгоно.

- Монгол ахуйд чиглэсэн амьдралын хэв маяг, соёлыг дэмжиж, хүүхдийг орон нутагтаа (**БАГИЙН ТӨВД**) суралцах нөхцөлийг бүрдүүлэх, Монголчууддаа **ХОТООС-ХӨДӨӨД, ГАДААДААС-ХӨДӨӨД, ДЭЛХИЙН ХӨДӨӨ** зэрэг урт хугацааны санаачилгыг эхлүүлнэ.

- **БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**-ийг дараах байдлаар тодорхойлно. Бүсүүдийг төрөөс дэмжих, зах зээлд нэвтрэх ялгаатай бодлого хэрэгжүүлнэ. Үүнд

**Баруун бүс:** Усалгаатай газар тариалан, Худалдаа үйлчилгээ, Олон ястан, үндэстний зан заншил, өндөр уулсын онцлогтой аялал жуулчлал

**Хойд бүс:** Шинжлэх ухаан, технологи, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, Боловсруулах үйлдвэр, Хил орчмын аялал жуулчлал, Боомт тээвэр ложистик

**Хангайн бүс:** Хөнгөн, хүнсний үйлдвэрүүд, Төрөлжсөн аялал жуулчлал, Археологийн судалгаа, Рашаан, амралт сувилал, Шашин, Ногоон хөгжлийн бүс

**Говийн бүс:** Уул уурхай, Хүнд үйлдвэрлэл, Барилгын материалын үйлдвэрлэл, Палеонтологийн судалгаа, Говийн аялал жуулчлал, Хүнсний үйлдвэрлэл

**Төвийн бүс:** Эрчимжсэн газар тариалан, Хүлэмжийн аж ахуй, Эдийн засаг, санхүүгийн, бизнесийн төв, Үйлдвэрлэл үйлчилгээ, Соёл урлаг, спорт

**Зүүн бүс:** Ногоон хөгжлийн бүс, Зүүн хойд Азитай холбох гүүр, Хил орчмын аялал жуулчлал, Боомт, тээвэр ложистик

- Тухайн бүсийн төв, аймаг, орон нутаг дахь ерөнхий боловсролын сургууль, **МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ**, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, технологийн коллеж, их, дээд сургуулиудын үүрэг, оролцоог нэмэгдүүлж, салбар дундын ялгааг арилгах зорилгоор мэргэжлийн багш, сурган хүмүүжүүлэгчдийг чадавхжуулах сургалт тогтмол хийх, **ШИЛЖИН СУУРЬШИЖ АЖИЛЛАХ БОЛОМЖ**-оор хангана.

БАРУУН БҮС:

- Бүсийн **БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ БООМТУУДЫН** (Боршоо, Тэс, Арцсуурь, Цагааннуур) хүчин чадал, тогтвортой ажиллагааг **САЙЖРУУЛАН**, тэдгээрт түшиглэсэн **ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ**-г эрчимжүүлж, **ТРАНЗИТ ТЭЭВРИЙГ** хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- **ЭКСПОРТЫН БАРИМЖААТАЙ** мал аж ахуйд суурилсан хүнс, хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх хүрээнд **УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН, ТЭЖЭЭЛИЙН ҮЙЛДВЭРҮҮДИЙГ** сэргээн хөгжүүлэх, **АЙМАГ** бүрийн онцлогийг шингээсэн органик **БҮТЭЭГДЭХҮҮНИЙ** үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- **ӨНДӨР УУЛСЫН** (тухайн орон нутгийн түүх, газар зүйн онцлог, олон ястан, үндэстний ахуйтай танилцах г.м) онцлог бүхий **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ** хүрээнд тухайн бүсийн маршрут, стандарт, менежментийг сайжруулна.
- Бүсийн оношилгооны төв, нарийн мэргэжлийн **ЭМНЭЛГИЙН ЧАНАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ** боломжоор хангана.
- **ХӨРӨНГӨ** оруулалтыг бүсийн суурь **ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ** чиглэлд илүү чиглүүлж, **ОЛОН УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААГ ДЭМЖИХ** бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

ХОЙД БҮС:

- Бүсийн **АЙМАГ** тус бүрийн онцлог, нөөцөд тулгуурлан, **ХҮНС, ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭР, ЭРЧИМЖСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАНГ ХӨГЖҮҮЛЭХ** зорилгыг нэн тэргүүнд тавина.
- **ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫГ** байгуулах ажлыг эхлүүлж, **ЭРЧИМ ХҮЧ**-ний ногоон, найдвартай эх үүсвэртэй болох боломжийг бүрдүүлнэ.
- Мэдлэг, инновацид суурилсан **АЖ ҮЙЛДВЭРИЙН БАРАА** бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, **ОХУ**-тай **ХИЛЛЭЖ БУЙ БООМТООР** дамжуулан бараа бүтээгдэхүүний **ИМПОРТ, ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ЖУУЛЧДЫГ** боомтуудаар шууд **ХҮЛЭЭН АВАХ** ажлыг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

*Handwritten signature*

- **“ЭРДЭНЭТ”** үйлдвэрлэл технологийн **ПАРКИЙН ТӨСЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЖ**, нийгэм–эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлнэ. **ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭРИЙН** судалгаа шинжилгээний хүрээлэнд тулгуурлан, **БҮСИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ** урт хугацаанд **ХЭРЭГЖҮҮЛЭХ** хүний нөөц, ур чадварын **НЭГДСЭН ТОГТОЛЦОО** бий болгох боломжийг бүрдүүлнэ.
- **ХӨВСГӨЛ, БУЛГАН** аймгуудын байгалийн үзэсгэлэнт газруудаар аялах гадаад, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлж, **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**–ыг бусад салбартай эдийн засгийн харилцан үр ашигтай байх, тогтвортой хөгжүүлэх **СТАНДАРТЫГ** бий болгоно.

#### ХАНГАЙН БҮС:

- Экосистемийн тэнцвэрийг хангасан **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ**–ийг **ХӨГЖҮҮЛЭХ** бодлогыг баримтална.
- Төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотойгоор соёл, урлаг, шинжлэх ухаан, оюуны чадавхид суурилсан **“УХААЛАГ ШИНЭ ХАРХОРИН”** (инновацийн төв) хотыг хөгжүүлж, **ЦАХИМ** технологийн мэргэжлийн сургуулийг төвлөрүүлэн, бүтээн байгуулалтуудыг эхлүүлнэ.
- Нүүдлийн соёл, түүх, шашин, байгаль, био–анагаах (амралт, рашаан сувилал) чиглэлийн **ТӨРӨЛЖСӨН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ** хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Бүсийн **АЖИЛЛАХ ХҮЧИЙГ, ОРОН СУУЦНЫ** бодлого, мэргэжлийн **ОРЧИН ҮЕИЙН** өрсөлдөх чадвартай **СУРГАЛТААР** татах бодлогоор дамжуулан хэрэгжүүлнэ.
- Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс гадна эрхтэн шилжүүлэх зэрэг **НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМНЭЛГИЙГ** төрөлжүүлэн хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

#### ГОВИЙН БҮС:

- Говийн бүсэд **УСНЫ ХОМСДОЛ** их байгааг хүлээн зөвшөөрч, гадагшаа урсаж байгаа Хангайн бүсийн **ГОЛ МӨРНИЙ УРСАЦЫН 3%**–ийг нь **ГОВИЙН БҮС РҮҮ** чиглүүлэх, нэмүү өртөг шингэсэн **УУЛ, УУРХАЙ, АЖ ҮЙЛДВЭРИЙН КЛАСТЕР**, экспортод чиглэсэн **СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ**–ний үйлдвэрлэлийг төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлээр хөгжүүлэх орчныг бүрдүүлнэ.
- Говийн бүсийн газар зүйн онцлог тогтоц, байгалийн ховор палеонтологийн олдворын **ҮЗЭСГЭЛЭН**, говийн малчин айлд **ЗОЧЛОХ**, нүүдэлчин ахуйтай **ТАНИЛЦАХ** зэргээр жуулчдыг татах, говийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг төр, хувийн хэвшилтэй хамтран гүйцэтгэнэ.
- Хүн амын боловсрол, бүсийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан нарийн мэргэжлийн **АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ** бэлтгэхэд чиглэсэн **СУРГАЛТ, СУРГАЛТЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД** анхаарах, **ТУСГАЙЛСАН БОДЛОГО** баримталж ажиллана.
- Говийн бүсэд ходоод, элэгний **ХОРТ ХАВДРААР** өвчлөх явдал газар авч байгааг онцгой анхаарч, нэн тэргүүнд ундны усыг **ЦЭВЭРШҮҮЛЭХ, ЗӨӨЛРҮҮЛСЭН УСААР** хангахад зорьж төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хамтран ажиллана.
- Бүсийн онцлогтой оюуны нөөц, чадамж шингэсэн **ИНГЭНИЙ** бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг экспортод чиглүүлэн **ХӨГЖҮҮЛЖ** байгаль орчиндоо ээлтэй, экологийн тэнцвэрийг хадгалах ач холбогдолтой **ЖИШЭЭ** дэлхийд бий болгоно.

#### ТӨВИЙН БҮС:


- **ИМПОРТЫГ ОРЛОХ ХҮНСНИЙ** бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн төдийгүй **НИЙСЛЭЛ ХҮН АМЫН ХЭРЭГЦЭЭГ** шинэ мах, сүү, хүнсний ногоо, өндөг, нарийн ногоо зэрээр хангаж, стандартын шаардлагад нийцсэн агуулах, зоорийн аж ахуй бүхий **БОРЛУУЛАЛТЫН СҮЛЖЭЭ**–г хөгжүүлнэ.
- **БОЛОВСРУУЛАХ САЛБАР** давамгайлсан эдийн засгийн бүтцийг бүрдүүлж, **ДОТООДЫН ХЭРЭГЦЭЭГ** хангахад томоохон хувь нэмэр оруулахуйц **ГАНГИЙН** үйлдвэрлэл, **АРЬС ШИРНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР**, үйлдвэрлэл, **ТЕХНОЛОГИЙН ПАРКУУДЫГ** байгуулахад бодлогоор дэмжин хөгжүүлнэ.

*М. Э. Д.*

- Агаарын тээврийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан, **ЧИНГИС ХААН** олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн, **ХӨШИГИЙН ХӨНДИЙН ЧӨЛӨӨТ БҮС, ШИНЭ ЗУУН МОД ХОТ** байгуулах ажлыг эрчимжүүлнэ.
- **ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ**-уудыг **ӨРГӨТГӨХ, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ** үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- Их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн хооронд хамтын ажиллагааг өргөжүүлж **ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨВ** байгуулах, хөгжүүлэх эрх зүйн орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

#### ЗҮҮН БҮС:

- Ази-Европыг холбосон **ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР** байгуулах, БНХАУ-ОХУ-ыг холбосон **ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СҮЛЖЭЭГ** бий болгох, **БООМТУУДЫГ ХӨГЖҮҮЛЖ**, олон улсын зэрэглэлд хүргэн, тээвэр, **ЛОЖИСТИКИЙН СҮЛЖЭЭ, ТӨВҮҮДИЙГ** бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Түүхэн, байгалийн болон тусгай зориулалтын хэрэгцээгээр **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ**, хөрш улс орнуудтай хамтарсан аялалын маршрут гарган салбарын хөгжилд төр, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Бүс нутгийн байгалийн өгөгдлийн давуу байдалд түшиглэн, шинэ махны **ХУДАЛДАА, ЭКСПОРТЫН** чиглэлээр **ХАГАС БЭЛЧЭЭРИЙН** мал аж ахуйг хөгжүүлэх, хөрөнгө оруулж буй **БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ** татварын хөнгөлөлт, урамшууллын **ЯЛГААТАЙ БОДЛОГООР** дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Бүс нутгийн **ХҮНИЙ НӨӨЦИЙН ДУТАГДЛЫГ** арилгахад чиглэсэн **ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ**, гэр бүл, өсвөр насныханд чиглэсэн богино ба урт хугацааны сургалтыг төлөвлөн, хэрэгжүүлэх асуудалд онцгой анхаарч ажиллана.
- **ХАВДРЫН** чиглэлээр үзлэг, оношилгоо хийдэг нарийн мэргэжлийн дагнасан **ЭМНЭЛЭГ БАЙГУУЛЖ**, эмч, эмнэлгийн ажилтны цалин хангамж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх замаар, бүсийн иргэдийн **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ӨНДӨР ТҮВШИНД ХҮРГЭХ** нөхцөл, боломжоор хангана.



#### ХӨДӨӨГИЙН НОГООН ХӨГЖИЛ, ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ

- **ХӨДӨӨГИЙН НОГООН ХӨГЖИЛ, ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ**-тай холбоотой судалгаа, шинжилгээний ажлыг дэмжиж, орон нутгийн байгаль орчныг хамгаалах, **УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГ**, ур чадварыг сурталчлан таниулах үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- Бүсийн онцлогтой, шуурхай арга хэмжээ авах эрх үүрэгтэй, чадавхитай **МАЛ АМЬТНЫ ЭМНЭЛЭГ, УРГАМАЛ ХАМГААЛАЛ**-ын **ТӨВҮҮД** байгуулах замаар хөдөө аж ахуйн нөөцөд нь тулгуурласан **НЭМҮҮ ӨРТӨГ ШИНГЭЭСЭН** үйлдвэрлэл бий болох суурь орчныг бий болгоно.
- Хөдөөгийн эдийн засаг, үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлыг **ХОРШОО**-ны системээр шийдвэрлэх ажлыг эхлүүлж, салбарт чиглэсэн тогтвортой хөгжлийн төслүүдэд орон нутгийн **ИРГЭДИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛЖ**, тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн төр, хувийн хэвшил, орон нутаг, олон улсын байгууллагуудай хамтран **ХӨГЖҮҮЛНЭ**.
- Хөдөө **ОРОН НУТГИЙГ СЭРГЭЭХ** үйл ажиллагаанд орчны **НӨХӨН СЭРГЭЭЛТ**, мод тарих, усны нөөцийг зохистой ашиглах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуй **ОРГАНИК** арга барилаар хөгжүүлэх чиглэл баримталж ажиллана.
- Хот, хөдөөгийн **ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ**-ний салбарт цахим систем ашиглан, шинэчлэл хийж, бүтээгдэхүүнийг **ХҮРГЭХ**, зах зээлд нэвтрүүлэх сүлжээг орон нутаг, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгоно.

*Handwritten signature*



## ГЭР БҮЛ, ХӨГЖИЛ БА БИЗНЕС

- Хот, хөдөөд **ГЭР БҮЛ ТӨВТЭЙ ӨРХИЙН БИЗНЕС ЭРХЛЭХ, УРГИЙН БИЗНЕС**–ийн суурийг тавих, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн **ИНКУБАТОР ТӨВ**–ийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сантай уялдуулах, иргэдийн хувь нийлүүлсэн хадгаламж зээлийн хоршоонд бага хүүтэй эх үүсвэр түр байршуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэл, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд байгуулна.
- Томоохон аж ахуйн нэгж, байгууллагын болон төрийн **ХУДАЛДАН АВАЛТЫГ ГЭР БҮЛ ТӨВТЭЙ БИЗНЕС**–ээс нийлүүлэхийг тогтмол дэмжиж, чанар стандартад нийцэх, технологийн сургалтуудыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.
- Гэр бүлийн **БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ**, инноваци, шинэ технологи бизнес нэвтрүүлэх, өрсөлдөх чадвар суулгах, бизнесийн өсөлт, хөгжилтийг **УРТ ХУГАЦААНД ДЭМЖИХ**–д чиглэсэн тогтолцоог бүрдүүлнэ.
- Гэр бүлийн бизнес эрхлэгчдийн хооронд **МЭДЭЭЛЭЛ** солилцох, **ТУРШЛАГА** хуваалцах боломжийг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд гарах боломжийг цахим тогтолцоогоор дамжуулан бий болгоно.
- **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ** болон бусад салбарт **БОЛОВСРОЛ** олгох сургалтыг дэмжих, инноваци, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, хөдөөгийн иргэд, гэр бүлүүдэд зориулсан мэргэжлийн боловсрол, **УР ЧАДВАР**–ыг дээшлүүлэх цахим тогтолцоог ХААИС болон бусад их, дээд сургуулиудтай хамтарч бий болгоно.

## ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД, ГАДААД БОДЛОГО БА БАТЛАН ХАМГААЛАХ

### ГАДААД ДАХЬ МОНГОЛЧУУД

- **ГАДААДАД** ажиллаж, амьдарч байгаа **ИРГЭДИЙНХЭЭ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ**, шаардлагатай тохиолдолд туслалцаа, дэмжлэг (эмч, хуульч гэх мэт) үзүүлэх **ТӨВ**–үүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд өргөжүүлнэ.
- Гадаадад байгаа иргэдийн **ХҮҮХДҮҮД** улс үндэснийхээ өв соёл, уламжлал соёл, **ЭХ ХЭЛЭЭ СУРАХ**, хадгалж үлдэх эрх бололцоогоор хангагдсан, **МОНГОЛ СУРГУУЛЬ, БОЛОВСРОЛЫН** болон **МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ**–үүдийг байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дэмжинэ.
- **СОЁЛ, УЛАМЖЛАЛАА ДЭЭДЛЭН** Монгол эх орноо таниулж, **СУРТАЛЧЛАХ** зорилгоор Монголын өдөр, Нээлттэй өдөрлөг, Наадам зэрэг уламжлалт баярын арга хэмжээг зохион байгуулахад нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дэмжлэг, туслалцаа үзүүлж, **МОНГОЛ БАХАРХАЛЫН ӨДРИЙГ "ӨНДӨР ДЭЭДСИЙН ХИШИГ ӨДӨР"** болгон дэлхий даяар тэмдэглэдэг болно.
- Төрийн үйлчилгээний **ЦАХИМ ПЛАТФОРМУУД, НОМЫН САНГУУДАД** нэвтрэх, **ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЭГШ БОЛОМЖ**–ийг бүрдүүлж ажиллана.
- Гадаадад байгаа иргэд **МОНГОЛООС БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, ЭКСПОРТЛОХ ҮЙЛЧИЛГЭЭ** үзүүлэх, эх орондоо бизнес эхлүүлэх, энэ чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө авах ажлыг дэмжих хүрээнд **БУЛАГ** цахим тогтолцоог бий болгоно. **ГАДААД ХАРИЛЦАА, ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ** бүрдүүлэхэд онцгой анхаарна.

### ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХУДАЛДАА

- **ОЛОН УЛСЫН ЭНХИЙГ САХИУЛАХ**, аюулгүй байдлыг хангахад олон улсын байгууллага, түнш улс орнуудтай **ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛНЭ**.



- Олон улсын **ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ЭКСПОРТ**-ын чиг баримжаатай салбарт түлхүү хамтран ажиллана.
- Гадаад улс, оронтой хийх **ХОЁР ТАЛТ ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ**-ийн хэлэлцээрт бараа бүтээгдэхүүний **ХУДАЛДАА**, гарал үүслийн журам, гаалийн горимыг харилцан тохиролцоо, эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуй, худалдаан дахь техникийн **СААД ТОТГОРЫГ АРИЛГАХ**, худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, оюуны өмч, цахим худалдаа, өрсөлдөөний бодлого, **МАРГААН ШИЙДВЭРЛЭХ** зэрэг тодорхой асуудлаар зохицуулалт хийх тухай тусгана.
- Олон улсын боловсрол, судалгаа шинжилгээ, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны хүрээнд **ИХ, ДЭЭД СУРГУУЛИУД, СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГУУД** хооронд солилцоо, хамтарсан төслүүдийг хөгжүүлж, **ШИНЭ МЭДЛЭГ**, технологийг бий болгоход идэвхтэй хамтран ажиллана.
- Соёл урлагийн салбарт олон улсын наадам, фестиваль, үзэсгэлэн, урлаг-соёлын солилцооны өргөн цар хүрээтэй арга хэмжээ зохион байгуулж, **МОНГОЛ УРЛАГ, СОЁЛ**-ыг **ДЭЛХИЙН ТАВЦАНД** таниулж, сурталчлах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд бодитой хувь нэмрээ оруулна.


## БАЙГАЛЬ ОРЧИН

- Монгол Улсын **ЕРӨНХИЙЛӨГЧИЙН** санаачилсан **ТЭРБУМ-МОД** хөдөлгөөнд хууль эрх зүйн болон **САНХҮҮЖИЛТИЙН ШИНЭЛЭГ ОРЧИН** бий болгож, мэргэжлийн байгууллагуудыг дэмжих замаар хамтран ажиллаж, ногоон эдийн засгийг дэмжиж, инноваци, технологи нэвтрүүлнэ.
- Монгол Улс 2030 он гэхэд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувьд хүргэх тухай санаачилгыг дэмжиж, биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах ажлыг эрчимжүүлж, **МАЗААЛАЙ, ИРВЭС, ЦАГААН ШОНХОР, ТҮЛ** зэрэг санаачилгыг хэрэгжүүлж эхлүүлнэ. Байгаль орчныг хамгаалах чадавхи, байгаль орчны ажилтны ажиллах нөхцлийг олон улсын түвшинд хүргэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- Хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр бүс нутгийн болон дэлхийн шилдэг туршлагаас хуваалцах, тогтвортой хөгжлийн зорилтыг хангах, талуудын хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх **НЭГ ДЭЛХИЙ ФОРУМ**-ыг хоёр жилд нэг удаа уламжлал болгон зохион байгуулна.
- Эрчим хүчний хэмнэлт, ногоон технологи, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн инновацийг хөгжүүлэх, хог хаягдлыг бууруулах зэрэг тогтвортой хөгжлийн шийдлүүдийг **СО<sub>2</sub>** буюу **НҮҮРСТӨРӨГЧ**-ийн **ЗАХ ЗЭЭЛ**-тэй холбож, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2030 он хүртэл бууруулах зорилтын хүрээнд **МӨНГӨЖҮҮЛЭН** эдийн засгийг дэмжихэд хувь нэмэр оруулна.
- **ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА** болон бусад улсын **ЗАСГИЙН ГАЗАРТАЙ** хамтран, байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих **ГЛОБАЛ АСУУДЛУУД**-ыг шийдвэрлэхэд хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ.

## БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ

- Орчин үеийн, мэргэжлийн, зэвсэгт хүчин, боловсон хүчнийг бэхжүүлэх хүрээнд **АНГИ НЭГТГЭЛ**-үүдийн **ДЭД БҮТЭЦ**-ийг **ОЛОН УЛСЫН СТАНДАРТ**-д нийцүүлэн хөгжүүлэх, мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, дээшлүүлэх зорилгоор сургалт, сургуулилалт, дадлага тогтмол хийх санаачилгыг хэрэгжүүлнэ.
- **ХИЛ ХАМГААЛАЛ**-д орчин үеийн **ДРОН, САНСРЫН ТЕХНОЛОГИ, ХЯНАЛТЫН КАМЕР, ЦАХИЛГААН ХЯНАЛТ, АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМҮҮД**-ийг ашиглан, өндөр зэрэглэлд хүргэнэ.
- Батлан хамгаалах ажиллагааг явуулах чадвартай, олон талт, олон улсын стандартад нийцсэн **ОРЧИН ҮЕИЙН ЗЭВСЭГЛЭЛ**-ийн шинэ системтэй болох ажлыг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд эрчимжүүлнэ.
- Зэвсэгт хүчний техник, технологийн сургалтыг **ВИРТУАЛ БА ДИЖИТАЛ** сургалтын системүүдийг ашиглан явуулах, **ХИЙМЭЛ ОЮУН УХААН, РОБОТ** технологиор сургалтын чанарыг сайжруулж, мэргэжлийн ур чадварыг өндөр түвшинд хүргэнэ.

- Мэргэжлийн зэвсэгт хүчний хөгжилд **ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**-г бэхжүүлж, батлан хамгаалах салбарын олон улсын стандарт, дүрэм журамд нийцүүлэн ажиллаж, хээрийн дасгал сургуулилалт, семинар, сургалтад **ОРОЛЦОХ**, мэдээлэл, туршлага харилцан солилцох боломжийг дэмжинэ.



*Handwritten signature*